



УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ

2018 оны 6 дугаар сарын 30-наар дуусгавар
болсон улирлаар

УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ
(2018 оны 6 дугаар сарын 30-наар дуусгавар болсон улирлаар)

Агуулга

Хоёрдугаар улирлын онцлох үйл явдлууд	4
Корпорацийн танилцуулга	5
Хэтийн төлөв, стратеги	7
Санхүүгийн жилийн түүвэрлэсэн мэдээлэл.....	7
Үйл ажиллагааны хэлэлцүүлэг	8
Улирлын үр дүнгийн хураангуй.....	10
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ба капитал нөөц.....	10
Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл.....	11
Төслийн товч танилцуулга.....	12
Баян Хөндий алтны төсөл.....	12
Алтан Нар алт-полиметаллын төсөл	21
Алтан Сум алтны төсөл (Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд).....	31
Улаан зэс-алтны порфирийн төсөл.....	33
Зуун Мод молибденийн төсөл (Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд байрлана).....	34
Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл (Хөвийн хар тусгай зөвшөөрлийн талбайд байрлана).....	34
Гэрээгээр хүлээсэн үүрэг.....	35
Балансын гадуурх зохицуулалт.....	35
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол	35
Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт.....	36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарах ирээдүйн өөрчлөлтүүд	37
Санхүүгийн хэрэгсэл ба бусад эрсдэл	38
Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт	40
Мэргэшсэн этгээд.....	40

Энэхүү 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн Удирдлагын хэлэлцүүлэг ба Дүн шинжилгээ (“УХДШ”) нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпопраци (“Эрдэнэ” эсвэл “Компани” эсвэл “Корпораци” гэх)-ийн 2017 оноос 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон, аудит хийгдээгүй 3 болон 6 сарын завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан болон 2016-2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тэдгээрийн тодруулгуудын хамт хэрэглэгдэх бөгөөд тус Корпорацийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд хамаарна. Корпорацийн завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг Канад доллараар илэрхийлж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу боловсруулсан.

Энэхүү хэлэлцүүлэг нь “Урьдчилсан таамаглал” гэж үзэж болохуйц тодорхой мэдээллүүдийг агуулсан болно. Түүхэн баримтат мэдээдлээс бусад энэхүү тайланд дурдагдах боломжит нөөц, хайгуулын өрөмдлөг, тэсэлгээ, төсөвт санхүүгийн үр дүн, Корпорацийн хүлээж буй үйл явдал, хөгжүүлэлт зэрэг мэдээллүүд нь алс хэтийг угтуулан харсан мэдээллүүд юм. Ийнхүү урьдчилсан таамаглал (Корпораци, түүний охин компаниудын тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа, эдийн засаг, зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, ашигт малтмалын үнэ, бодит нөөц тогтоолт зэрэгтэй холбоотой төсөөллүүдийг багтаах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй)-д тулгуурласан алсыг харсан мэдээллүүдэд илэрхийлсэн хүлээлтүүд нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй бөгөөд бодит үр дүн, хөгжүүлэлт нь зах зээлийн үнэ, хайгуул ба үнэлгээний үр дүн, капитал болон санхүүгийн тасралтгүй хүртээмжтэй байдал, эдийн засаг, зах зээл, бизнесийн ерөнхий нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан тэдгээр алс хэтийн төсөөллөөс материаллаг байдлаар ялгаатай байж болно.

Дээр тодорхойлсон эрсдэлийн хүчин зүйлс нь Корпорацид нөлөөлөхүйц бүхий л хүчин зүйлсийг хараахан бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй. Нэмэлт хүчин зүйлсийг Корпорацийн www.sedar.com -д тавигдсан 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Корпорацийн жилийн мэдээ, тайлангийн “Эрсдэлийн хүчин зүйлс” хэсэгт тэмдэглэсэн болно.

Канад улсын үнэт цаасны хуулиар тодорхойлогдох энэхүү УХДШ-д тусгасан санхүүгийн аливаа хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг Корпорацийн удирдлага тус УХДШ гарах өдрөөр батласан болно. Ирээдүйтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээж буй болон төлөвлөж буй ажлын талаар мэдээлэл өгөх зорилгоор санхүүгийн хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг өгч байгаа юм. Ийм хэтийн төлөв, ирээдүйн мэдээллүүдийг энэхүү УХДШ-д тусгаснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Хоёрдугаар улирлын онцлох үйл явдлууд

Хураангуй

- Корпораци нь Монгол Улсын баруун өмнөд зүгт урьд өмнө нээн илрүүлээгүй байсан, харин өдгөө Хөндий алтны бүс хэмээн тодорхойлогдоод байгаа өндөр агуулга бүхий алт, суурь металлын хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг нээн илрүүлэв.
- Корпорацийн хоёрдугаар улирлын хөтөлбөрүүд нь 100 хувь өөрийн эзэмшилд байдаг томоохон төслүүд болох Алтан нар, Баян хөндий (хоорондоо 16 км зайтай) гэх хоёр ордын нөөцийг тодорхойлж, нэмэгдүүлэх, тэдгээрийн ойролцоо алт, суурь металлын нэмэлт талбай илрүүлэн туршихад голлон чиглэнэ.


Баян хөндий алтны хайгуулын төсөл – Эрдэнийн 100% эзэмшил

- Корпораци 2 дугаар улиралд Баян хөндийд 4,584 метрийн өрөмдлөг хийсэн ба уг төсөл анх 2015 онд нээгдсэнээс хойш нийт 42,656 метрийн өрөмдлөгийн судалгаа хийгээд байна. Өрөмдлөгийн зорилго нь 2018 оны 3 дугаар улиралд нөөцийн эхний тооцоо гарахаас өмнө өндөр агуулга бүхий структурын цэгүүдийг турших, хүдэржилтийн гол бусүүдэд ойр зайтай өрөмдлөг хийхэд оршсон.
- Сүүлийн үеийн өрөмдлөгөөр 450 метр хүртэл өргөн, 1.3 км гаруй урт цаашид нэмэгдэх боломжтой алтны томоохон хүдрийн биет буйг амжилттай олж тогтоосон. 2018 оны 2-р улиралд илрүүлсэн олон тооны илэрцээс алтны агуулга өндөр байгааг харж болно. Тухайлбал:
 - ВКD-238 цооногт 21.6 г/т алтны агуулгатай 18 метрийн зузаантай интервал илэрсэн ба үүнээс 2 метр нь 169 г/т алтны агуулгатай,
 - ВКD-241 цооногт 4.4 г/т алтны агуулгатай 37 метрийн зузаантай интервал илэрсэн ба үүнээс 2 метр нь 50.5 г/т алтны агуулгатай,
 - ВКD-242 цооногт 16.9 г/т алтны агуулгатай 10 метрийн зузаантай интервал илэрсэн ба үүнээс 2 метр нь 17.5 г/т, 2 метр нь 56.8 г/т алтны агуулгатай,
 - ВКD-245 цооногт 11 г/т алтны агуулгатай 12 метрийн зузаантай интервал илэрсэн ба үүнээс 3 метр нь 35.6 г/т алтны агуулгатай,
 - ВКD-254 цооногт 2.6 г/т алтны агуулгатай 81 метрийн зузаантай интервал илэрсэн ба үүнээс 17 метр нь 9.2 г/т алтны агуулгатай байна.
- Баруун хойш чиглэлтэй гүний хагарал болон солбилцох хавтгайн структурын огтлолцол дээр, Мидфийлд бүс дэх боломжит тэжээгч бүсийг шалган өрөмдсөн. Энэ өрөмдлөгөөр 34.4 г/т алттай 7 м (ВКD-244) буюу Баян Хөндийн одоогоор мэдэгдэж буй хамгийн өргөн, алттай кварц-адулярын судлыг огтлосоноороо онцгой юм.
- Баян Хөндий төслийн өрмийн судалгааны үр дүнг RPMGlobal-д хүргүүлсэн бөгөөд 8-р сард Баян Хөндий төслийн анхан шатны нөөцийн тайланг танилцуулахаар төлөвлөж байна.
- Алтан Нар, Баян Хөндий төслийн анхан шатны эдийн засгийн тооцоолол болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авах үйл ажлын хүрээнд шаардлагатай техникийн судалгаанууд хийгдэж байна.

Алтан нар алт-полиметаллын төсөл –Эрдэнийн 100% эзэмшил

- Корпораци нь 2018 оны 5 дугаар сарын 10-нд Алтан нар төслийн шинэчилсэн нөөцийн тайланг танилцуулсан ба шинэчилсэн тайланд нөөц их хэмжээгээр өссөн үр дүнтэй гарсан. Компанийн 2015 оны 3 дугаар сард танилцуулсан Алтан Нар анхан шатны нөөцийн тайлантай харьцуулахад бодит алттай дүйцэх (“AuEq”) нөөц нь 208%, боломжит AuEq нөөц нь 172%-аар өссөн. Компанийн тооцоолсноор Алтан Нар төслийн бодит нөөц нь дунджаар 2.8 г/т алттай дүйцэх (алтны дүйцэх нэгж “AuEq”) агуулгатай 5.0 сая тн хүдэрт буюу 452,900 унц, боломжит нөөц нь 3.4 сая тн хүдэрт 2.5 г/т AuEq (1.7 г/т алт, 7.9 г/т мөнгө, 1.4% хар тугалга, цайр) агуулгатай 277,100 унц агуулагдаж байна.
- Корпораци нь 2018 оны сүүлээр авах ашиглалтын тусгай зөвшөөрлийн материал бүрдүүлэх хүрээнд техникийн судалгаануудыг үргэлжлүүлэн хийж болно. Металлургийн туршилт, эдийн засгийн үнэлгээ, геотехникийн болон гидрогеологийн үнэлгээ болон бусад шаардлагатай судалгаануудыг нэмэлт судалгааны хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Монголын улсын баруун өмнөд зүгт орших Хөндий алтны бүс



Бүс нутгийн хайгуул

- Корпораци нь 11.4 км урт Баян хөндий тусгай зөвшөөрлийн талбайд Алтан сум, Хөндий Хойд талбайд төвлөрөн хайгуулын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Корпорацийн 2018 оны 2-р улиралд Алтан сум, Хөндий Хойд талбайд хийсэн тандалтын өрөмдлөгийн үр дүн 2018 оны 3-р улиралд гарна.
- Корпораци нь 2017 оны 3-р улиралд Баян Хөндий алтны төслийн чанх баруунт зүгт орших Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн 51%-ийг 100% хүртэлх хувиар худалдан авах нөхцөлтэйгээр худалдаж авсан. Он дуусахаас өмнө Улаан талбайд анхны өрөмдлөгөө хийхээр зэхэж байна.
- Эрдэнэ Ресурс нь Тек Ресурс Лимитэд компанитай хамтын ажиллагаа (“Хамтын ажиллагаа”)-г үргэлжлүүлэн Эдрэнгийн төрөнийн порфир болон порфиртой холбоотой хүдэржилтийн хэтийн төлөв бүхий талбайг ялгах, бүс нутгийн эрлийн ажлаа үргэлжлүүлэн, Монгол улсын баруун өмнө хэсэгт хайгуулын хэтийн төлөв бүхий талбайг хамтран илрүүлэхээр зорьж байна.

Байгууллага

- Корпораци нь 2018 оны 2-р улиралд Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-д хувьцаа гарган давхар бүртгүүлсэн анхны гадаадын хөрөнгө оруулалттай компани болж, захиалга даван биелүүлж, Монголоос \$1.38 сая доллар, үүнтэй зэрэгцэн олон улсын хөрөнгийн зах зээлээс \$4.12 сая долларын хөрөнгийг хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн.
- Энэхүү УХДШ гарах өдрөөр Корпорацийн эргэлтийн хөрөнгө ойролцоогоор \$3.95 сая доллар байна.

Корпорацийн танилцуулга

Эрдэнэ Ресурс нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр (TSX:ERD) хувьцаа арилжаалдаг, ашигт малтмалын хайгуул, төсөл хөгжүүлэлт хийдэг компани юм. Сүүлийн жилүүдэд Монголын баруун өмнө хэсэгт шинээр 7 алтны хэтийн төлөв бүхий талбайг (Хөндий алтны бүс) нээсэн бөгөөд тэдгээр 7 талбайн 2 нь хөгжүүлэлт хийхэд тохиромжтой өндөр агуулга бүхий хэтийн төлөвтэй гэгдэх Баян Хөндий, Алтан Нар ордууд юм. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Баян Хөндий талбайн гадаргаас нэн өндөр агуулгатай алтны дээж авснаар энэхүү талбайд Компани гол анхаарлаа хандуулсаар байна. Өрөмдлөг, хайгуулын ажлаар Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн зэрэгцээ болон хойд хэсгээр хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг илрүүлээд байгаа нь алтны нэмэлт нөөц (Алтан Сум болон Хөндий хойд талбай) болох тун өндөр магадлалтай байгаа билээ.

Корпорацийн 100% эзэмшил бүхий Баян Хөндий (Rich Valley) алтны төслийг 2015 оны 2 дугаар улиралд нээж илрүүлэн 2015 оны 4-р улиралд анхны өрөмдлөгийг хийж, эхний цооногоос 14 метрийн гүнд 27.5 г/т алтны агуулгатай 7 метр зузаантай интервал илрүүлсэн. Баян Хөндий нь алтны өндөр агуулгатай, гадаргад ойр, хялбар металлургийн нөхцөлтэй тул Корпорацийн голлон төвлөрөх төсөл болоод байна. Корпораци нь Баян хөндийд нийтдээ 42,656 тууш метр бүхий 255 алмазан цооног өрөмдөөд байгаа юм. Өнөөг хүртэл хийсэн өрөмдлөгөөр хүдэржилт нь гадаргаасаа эхэлдэг Страйкер бүс, залуувтар, хүдэржилтийн дараах Цэрдийн хучаас доор зүүн хойш сунаж тогтсон Мидфийлд болон Хойд Мидфийлд бүс гэсэн үргэлжлэх магадлал өндөртэй, өндөр агуулгатай алтны хүдэржилт бүхий 3 гол цэгийг олж тодорхойлсон. Энэ гурван бүсийн хоорондох алт агуулагч бүсүүд нь өргөнөөрөө 50 метрээс их, 5 г/т алтны илэрцтэй байж болзошгүй. 2017 онд хийсэн хэмжээст өрөмдлөгөөр Страйкер бүсээс зүүн хойш 200м зайтай орших Мидфийлд бүсэд тохиолдсон хүдэржилт нь залуувтар хучдасын доогуур багадаа 280м цааш сунаж тогтсон байв. Одоогоор Баян Хөндийн Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүдээс 42 метрийн гүнд 80 метр 6.0 г/т алтны илэрц бүхий ВКD-98, 1 метр 2,200 г/т алтны илэрц бүхий 1 метр 158 г/т алтны агуулгатай ВКD-231 гэх мэт хамгийн өндөр агуулга бүхий хүдэржсэн интервалууд илрээд байна.

Эрдэнийн 100% эзэмшдэг Алтан Нар ('Golden Sun') төсөл Баян Хөндий төслийн талбайгаас баруун хойш 16 км зайтай оршдог бөгөөд 5.6 x 1.5 км хүдэржилттэй корридор эрдэсжсэн 18 (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөвт талбайг агуулдаг. Анхны хоёр нээлт болох "Нээлтийн бүс" (НБ) болон Хойд Холбоос (ХХ) бүсүүд нь Эрдэнэ Ресурсын 2018 оны 2-р улиралд гаргасан нөөцийн шинэчилсэн тайланд мэдээлсэнээр хамгийн ихээр судлагдсан газрын гадаргууд дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг агуулдаг. Мөн металлургийн боловсруулалтын дэлгэрэнгүй туршилтын ажил болон 2015 оны 3-р улирлын нарийвчилсан судалгаа, суваг малталтын гол талбайнууд юм. 2016 оны 4-р улиралд Корпораци НБ дэх структурын огтлолцолд (TND-101 цооног) өрөмдлөг хийж үзэхэд урьд өмнө Алтан Нар талбайд ажиглагдаж байгаагүй, гадаргаас 170 метрийн гүн хүртэл тогтвортой хүдэржилт бүхий өндөр агуулгатай алтны бүс огтлогдсон. Энэ нь геофизикийн судалгаагаар ажиглагдсан хөндлөн огтлолтой перпиндикуляр өрөмдсөн хайгуулын цооног юм. Энэхүү шинээр илрүүлсэн өндөр агуулгатай хүдэржилтийн бүсэд 2017 оны 2-4-р улиралд талбай тэлэх өрөмдлөгийн ажлуудыг хийсний дүнд 97 метрийн гүнд 10.3 г/т алтны агуулгатай 20 метрийн зузаантай интервал бүсийн дотор 29.7 г/т алтны агуулгатай 5 метрийн интервал (TND-110 цооног) бүхий хэд хэдэн огтлолцсон хүдэржилтийн бүс илрүүлсэн. Эдгээрээс 16 хэтийн төлөв бүхий талбайн үр дүн 2018 оны 2-р улирлын ашигт малтмалын нөөцийн шинэчилсэн тайланд тусгагдсан боловч эдгээр үр дүнг эхний шатандаа яваа бөгөөд Корпорацийн зүгээс эдгээрийг хэтийн төлөв бүхий талбайг нэмэлт нөөц агуулж байх магадлалтай хэмээн үзэж байгаа юм.

Ирээдүйд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахтай холбогдуулан техникийн төрөл бүрийн судалгаа хийсэн, Баян Хөндий, Алтан Нар алтны төслүүдийн эдийн засгийн холбогдох тооцоо, судалгаануудыг ч мөн үргэлжлүүлэн хийсээр байна.

Баян Хөндий, Алтан Нар төслүүдэд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхийн сацуу Корпораци нь өндөр агуулга бүхий үнэт болон суурь металлын төслүүдийг нэмж илрүүлэх, 2017 оны 3-р улиралд хөрөнгө оруулсан Улаан хайгуулын талбай зэрэгтэй ижил цар хүрээг нэмэгдүүлэх худалдан авалтуудыг хийхээр зорьж байна. Эрдэнэ нь Тек Ресурс Лимитэд компанитай хамтын ажиллагаа ("Хамтын ажиллагаа")-г үргэлжлүүлэн Эдрэнгийн террейний порфир болон порфиртой холбоотой хүдэржилтийн хэтийн төлөв бүхий талбайг ялгах, бүс нутгийн эрлийн ажлаа үргэлжлүүлэн, Монгол улсын баруун өмнө хэсэгт хайгуулын хэтийн төлөв бүхий талбай хамтран илрүүлэхээр зорьж байна. Корпорацийн Баян Хөндий, Алтан Нар, Алтан Сум, Улаан, Хөвийн Хар, Зуун Мод төслүүд нь Төктэй байгуулсан түншлэлийн хүрээнд хамаарахгүй болно.

Сэндсторм Гоулд Лтд. хувьцаа захиалгын гэрээ

2016 оны 04 сарын 21-нд Корпоаци нь Сэндсторм Гоулд Лтд. ("Sandstorm Gold Ltd") (цаашид "Сэндсторм" гэх) компанитай нийт \$2,500,000 долларын хоёр үргэлжилсэн хэлцлийг хийсэн. Эхний хэлцлээр, Сэндстормын нэгж хувьцаа нь \$4.66 бүхий нийт \$1,500,000-ын үнэлгээтэй 321,888 ширхэг хувьцааны хариуд Корпорацийн Цэнхэр Номин болон Хөндий тусгай зөвшөөрлүүдэд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг ("NSR" эсвэл "Net Smelter Royalty") ("БЦА-ийн Төлбөр") Сэндстормд ирээдүйн олборлох үйл ажиллагаанаас хуваарилахаар тохирсон ба хувьцааны үнийг тогтоохдоо 2016 оны 04 сарын 14-ний ТХБ дэх Сэндстормын 10 өдрийн жигнэсэн дундаж ханш дээр үндэслэсэн. Хоёр дахь хэлцлээр, Сэндстормын бэлнээр төлсөн \$1,000,000-ын хариуд нэгж хувьцааг \$0.20-аар үнэлэн, Корпорацийн 5 сая ширхэг хувьцааг нэмж гарган Сэндстормд борлуулсан. Сэндсторм нь хэлцлийн дагуу нэмж гаргасан хувьцааг царцаах үүрэг хүлээсэн бөгөөд энэ нь 2017 оны 10 сарын

14-ний өдөр дуусгавар болсон. Корпораци нь БЦА-ийн Төлбөрийг 1.0% хүртэл бууруулах опцион эрхтэй, ингэхийн тулд хэлцэл хийгдсэнээс хойш 3 жилийн хугацаанд 1.2 сая долларыг Сэндстормд төлсөнөөр БЦА-ийн төлбөрийг 50% бууруулах боломжтой. Сэндсторм нь Хөндий болон Цэнхэр Номингийн тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн БЦА төлбөрийн санхүүжилтэд хориг тавих эрхтэй.

БЦА-ийн төлбөрт тооцоолж байсан \$1.5 сая доллараас \$876,972 долларыг Алтан Нарын Хайгуул, үнэлгээний капиталжуулсан хөрөнгөд оруулсан нь хэлцэл хаагдах өдрөөр үлдэгдэл болсон. Үлдсэн \$623,028 долларыг тайлант хугацааны үр дүнгийн тайланд ашиг гэж үзсэн.

Тек Ресорсиз Лимитед (Teck Resources Limited) компанитай байгуулсан түншлэл

Түншлэлийг 2013 оны 4 дүгээр сард Монгол Улсын баруун өмнөд зүгт Транс Алтай бүсэд байрладаг Корпорацийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн геологи хайгуулын ажлыг санхүүжүүлэх, хайгуулын ажил хийх хүрээнд Тек Ресорсиз Лимитэд компанитай (“Teck Resources Limited”) (“Тек”) опцион болон хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх гэрээний (хамтад нь “Тек гэрээ”) дагуу байгуулсан. Гэрээний нөхцөлд заасны дагуу Тек нь Корпорацид 3 сая долларын хөрөнгө оруулах хүртлээ эсвэл Корпорацийн зарласан хувьцааны 19.9%-ийг эзэмших (аль нэг нь түрүүлж хийгдэх) хүртэл хаалттай хүрээнд Корпорацийн хувьцааг тухайн үеийн 10 өдрийн жигнэсэн дундаж ханш дээр 10%-ийг нэмж тооцсон үнээр худалдан авна. Хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын 85% нь Корпорацийн хайгуулын ажилд зарцуулагдахаар төлөвлөгдсөн бөгөөд Тек нь дахин санхүүжилтын аргаар шинэ төслүүдэд 75% хүртэл эзэмших боломжтой 2 үе шаттай опцион эрхтэй.

2013 оны 2-р улирлаас 2017 оны 1-р улирлын хооронд гэрээний дагуу Тек нь дээр дурдсанчлан гэрээний анхдагч нөхцөлийг хангаж, хаалттай 6 санхүүжилтээр нийт \$3.0 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн. Тек нь Корпорацийн нэрлэсэн болон өөрийн зөвшөөрсөн аливаа төслүүдэд түншлэлийн гэрээ хийх эрх нь 2020 оны 1 дүгээр улирлыг дуустал хүчинтэй.

Хэтийн төлөв, стратеги

Баян Хөндийн өрөмдлөгийн ажил 2018 оны 2-р улиралд дуусмагц Корпораци нь Баян Хөндийн өрөмдлөгийн ажлын үр дүнг АрПиЭмГлобал (RPMGlobal) компанид хүргүүлэн, анхан шатны нөөцийн тайланг (NI 43-101) боловсруулж эхлүүлээд байна. Энэхүү тайлан нь 2018 оны 2-р улиралд зарлагдах Алтан нар ордын нөөцийн шинэчлэгдсэн тайлантай хавсрана. Баян Хөндийн нөөцийн тайлан 2018 оны 3-р улиралд багтаж бэлэн болох төлөвтэй байгаа юм. Уурхайн болон боловсруулалтын төрөл бүрийн арга, хүдрийн төрөлд тулгуурлан ашигт малтмал, ордуудын онцлог шинжийг тодорхойлсны дараа Баян Хөндий, Алтан Нар төслүүдийн эдийн засгийн урьдчилсан үнэлгээг хийж гүйцэтгэх ба эдгээр үнэлгээг 2019 онд улам баяжуулж, дэлгэрүүлнэ. Эдгээр үнэлгээнд үндэслэн уурхай, үйлдвэрийн бүтээн байгуулалт, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийг эхлүүлэх шийдвэрийг гаргана. Бүс нутгийн хайгуулыг үргэлжлүүлэн хийх хэдий ч Корпораци нь Баян Хөндий, Алтан Нар төслүүдийг тэлж хөгжүүлэх, Хөндий бүсийн орчимд хэтийн төлөвүүдийг үнэлэх, хөгжүүлэхэд нэн тэргүүнд голлон анхаарч ажиллана. Корпораци нь 2019 оны 1 дүгээр улирлыг хүртэл төсөвлөгдсөн зардлыг санхүүжүүлэх хангалттай хэмжээний бэлэн мөнгө, хөрөнгөтэй.

Санхүүгийн жилийн түүвэрлэсэн мэдээлэл

Корпорацийн аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас дараах мэдээллийг түүвэрлэн авав. Үүнд:

Хувьцааны тоо хэмжээнээс бусад дүнг мянган Канад доллараар илэрхийлэв.

12-р сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жил	2017 он	2016 он	2015 он
Ашиг	N/A	N/A	N/A
Алдагдал	\$ 4,027	\$ 2,500	\$ 12,608
Нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан алдагдал	\$ 0.03	\$ 0.02	\$ 0.14
Нийт актив	\$ 14,946	\$ 4,293	\$ 2,522
Нийт урт хугацаат ер төлбөр	N/A	N/A	N/A
Зарласан мөнгөн ногдол ашиг	N/A	N/A	N/A

Үйл ажиллагааны хэлэлцүүлэг

2017-2018 он, 6-р сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын мэдээлэл

Доорхи хүснэгтэд тайлант хугацаанд капиталжсан зардлуудыг багтаасан 2017-2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 3 сарын хугацааны хайгуул, үнэлгээний зардлыг үзүүлэв. “Төслийн хураангуй” хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласанчлан хайгуулын ажлууд нь Хөндий, Цэнхэр номин, Улаан тусгай зөвшөөрлийн талбайнуудад голлон төвлөрсөн болно.

2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 3 сарын хугацаанд	Хөндий	Цэнхэр номин	Зуун мод	Улаан ба бусад	Нийт
Хайгуулын зардал					
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж, шинжилгээ	899,496	17,755	715	43,894	961,860
Тусгай зөвшөөрлийн зардлууд	5,223		70,074	2,051	77,348
Уурхайн судалгаа, зөвшөөрөл	30,102	42,074			72,176
Хайгуул, кэмп, хээрийн ажлууд	475,478	79,286	20,132	205,403	780,299
Оролцогч талуудтай харилцах	51,135	51,135			102,270
Томилолт болон бусад	48,169	18,570		9,568	76,307
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр				345,844	345,844
Монгол дахь оффисийн зардлууд				46,071	46,071
Хайгуулын нийт зардал	1,509,603	208,820	90,921	652,831	2,462,175
Капиталжуулсан зардал	(1,509,603)	(208,820)	(70,074)	(663)	(1,789,160)
2018 онд зарлагдсан хайгуулын зардлууд			20,847	652,168	673,015

Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2018.04.01	\$ 8,337,490	\$ 2,168,774	\$ 796,575	\$ 958,384	\$12,261,223
Нэмэлт	1,509,603	208,820	70,074	663	1,789,160
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(48,373)	(16,453)	(5,914)	(9,209)	(79,949)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2018.06.30	\$ 9,798,720	\$ 2,361,141	\$ 860,735	\$ 949,838	\$13,970,434

2017 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон хугацаанд	Хөндий	Цэнхэр номин	Зуун мод	Улаан ба бусад	Нийт
Хайгуулын зардал					
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж,	2,235,743	245,266	658		2,481,667
Тусгай зөвшөөрлийн зардлууд	5,464		74,062	375	79,901
Уурхайн судалгаа, зөвшөөрөл	70,454	53,058			123,512
Хайгуул, кэмп, хээрийн ажлууд	601,413	99,100	13,310	148,353	862,176
Оролцогч талуудтай харилцах	12,115	10,796		8,653	31,564
Томилолт болон бусад	37,985	14,755	300	271	53,311
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр				584,416	584,416
Монгол дахь оффисийн зардлууд				64,474	64,474
Хайгуулын нийт зардал	2,963,174	422,975	88,330	806,542	4,281,021
Капиталжуулсан зардал	(2,963,174)	{422,975}	{74,062}	{375}	(3,460,586)
2017 онд зарлагдсан хайгуулын зардлууд			14,268	806,167	820,435

Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2017.04.01	\$ 2,144,876	\$ 616,186	\$ 753,841	\$ 593	\$ 3,515,496
Нэмэлт	2,963,174	422,975	74,062	375	3,460,586
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(23,883)	(8,506)	(9,314)	(8)	{41,711}
Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2017.06.30	\$ 5,084,167	\$ 1,030,655	\$ 818,589	\$ 960	\$ 6,934,371

Байгууллага, захиргааны зардал 2017 оны мөн үеийнхтэй (\$1,264,294 доллар байсан) харьцуулахад 2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 3 сарын хугацаанд \$791,439 болж, \$472,855 доллараар буурсан (доорх хүснэгтийг харна уу). Захиргаа үйлчилгээний зардал 2018 онд төлсөн гүйцэтгэлийн урамшууллыг багасгасантай холбоотойгоор \$90,500 доллараар буурсан. Хөрөнгө оруулагчидтай харилцах болон маркетингийн зардал буурч, 2017 оны 2-р улиралтай харьцуулахад 2018 оны 2-р улиралд \$42,200 доллараар буурсан нь маркетингийн үйл ажиллагааг бууруулж, хурал чуулганы оролцоог бууруулсанаас үүдсэн. Хувьцаанд суурилсан бэлэн бус нөхөн төлбөр \$359,600 доллараар буурсан. Корпорацийн тодорхой албан тушаалтнууд, захирлууд болон ажилтнуудад 2018 оны 2-р улиралд ойролцоогоор 2.8 сая опцион олгосон (2017 оны 2-р улиралд 2.6 сая опцион олгосон). 2017 онд опцион олгосноос хойш хувьцааны үнэ буурсантай холбоотойгоор 2018 онд олгосон опционы тооцоолсон бодит үнэ цэнэ 2017 оныхоос бага байгаа юм.

6-р сарын 30-наар дуусгавар болсон 3 сарын хугацаанд

	2018 он	2017 он	Өөрчлөлт
Захиргаа үйлчилгээ	\$ 149,359	\$ 239,872	\$ (90,513)
Элэгдэл, хорогдол	1,554	1,665	(111)
Захирлуудын төлбөр, зардал	51,107	43,729	7,378
Хөрөнгө оруулагчидтай харилцах, маркетинг	24,978	67,199	(42,221)
Оффисийн болон бусад ажил	34,783	27,575	7,208
Мэргэжилтний хөлс	55,676	40,015	15,661
Эрх зүйн нийцлийг хангах	26,481	30,587	(4,106)
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	430,823	790,456	(359,633)
Унаа, байр	16,678	23,196	(6,518)
	\$ 791,439	\$ 1,264,294	\$ (472,855)

2017 - 2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хугацаанд

Доорх хүснэгтэд тайлант хугацаанд капиталжсан зардлуудыг багтаасан 2017 он болон 2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хугацааны хайгуул, үнэлгээний зардлыг үзүүлэв. “Төслийн хураангуй” хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласны дагуу хайгуулын ажлууд нь Хөндий, Цэнхэр номин, Улаан тусгай зөвшөөрлийн талбайнуудад голлон төвлөрсөн болно.

2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон хугацаанд	Хөндий	Цэнхэр номин	Зуун мод	Улаан ба бусад	Нийт
Хайгуулын зардал					
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж, шинжилгээ	899,977	18,420	1,380	50,825	970,602
Тусгай зөвшөөрлийн зардлууд	5,223	-	70,074	2,051	77,348
Уурхайн судалгаа, зөвшөөрөл	62,362	60,760	-	-	123,122
Хайгуул, кэмп, хээрийн ажлууд	760,686	151,604	29,568	301,199	1,243,057
Оролцогч талуудтай харилцах	74,871	65,077	-	-	139,948
Томилолт болон бусад	78,213	31,161	-	18,207	127,581
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	-	355,037	355,037
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	-	143,386	143,386
Хайгуулын нийт зардал	1,881,332	327,022	101,022	870,705	3,180,081
Капиталжуулсан зардал	(1,881,332)	(327,022)	(70,074)	(2,051)	(2,280,479)
2018 онд зарлагадсан хайгуулын зардлууд	-	-	30,948	868,654	899,602

Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2018.01.01	\$ 7,715,388	\$ 1,985,444	\$ 765,795	\$ 928,216	\$ 11,394,843
Нэмэлт	1,881,332	327,022	70,074	2,051	2,280,479
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	202,000	48,675	24,866	19,571	295,112

Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2018.06.30 \$ 9,798,720 \$ 2,361,141 \$ 860,735 \$ 949,838 \$ 13,970,434

2017 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон хугацаанд

	Хөндий	Цэнхэр номин	Зуун мод	Улаан ба бусад	Нийт
Хайгуулын зардал					
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж, шинжилгээ	2,263,520	247,031	1,590	259	2,512,400
Тусгай зөвшөөрлийн зардлууд	5,464	-	74,062	375	79,901
Уурхайн судалгаа, зөвшөөрөл	95,250	53,058	-	-	148,308
Хайгуул, кэмп, хээрийн ажлууд	841,045	144,269	26,280	220,055	1,231,649
Оролцогч талуудтай харилцах	12,382	11,063	-	9,864	33,309
Томилолт болон бусад	60,847	20,017	300	1,773	82,937
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	-	589,816	589,816
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	-	121,040	121,040
Хайгуулын нийт зардал	3,278,508	475,438	102,232	943,182	4,799,360
Капиталжуулсан зардал	(3,278,508)	(475,438)	(74,062)	(375)	(3,828,383)
2017 онд зарлагдсан хайгуулын зардлууд	-	-	28,170	942,807	970,977

Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2017.01.01	\$ 1,786,195	\$ 551,271	\$ 728,164	\$ 581	\$ 3,066,211
Нэмэлт	3,278,508	475,438	74,062	375	3,828,383
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	19,464	3,946	16,363	4	39,777
Хайгуул, үнэлгээний хөрөнгө, 2018.06.30	\$ 5,084,167	\$ 1,030,655	\$ 818,589	\$ 960	\$ 6,934,371

2018 оны 6-р сарын 30-наарх 6 сарын хугацаанд байгууллага, захиргааны зардал 2017 оны мөн үеийнхтэй (\$1,725,192 доллар байсан) харьцуулахад \$1,278,047 болж, \$447,145 доллараар буурсан (доорх хүснэгтийг харна уу). Захиргаа үйлчилгээний зардал 2018 онд төлсөн гүйцэтгэлийн урамшуулал багассантай холбоотойгоор \$72,600 доллараар буурсан. Хөрөнгө оруулагчидтай харилцах болон маркетингийн зардал 2017 онтой харьцуулахад \$100,500 доллараар багассан нь 2018 онд цөөн хурал чуулганд оролцоноос шалтгаалсан. Хувьцаанд суурилсан бэлэн бус нөхөн төлбөр \$280,644 доллараар буурсан. Корпорацийн тодорхой албан тушаалтнууд, захирлууд болон ажилтнуудад 2018 онд ойролцоогоор 3.1 сая опцион олгосон (2017 онд 2.6 сая опцион олгосон). Опцион олгосноос хойш 2017 онд хувьцааны үнэ буурсантай холбоотойгоор 2018 онд олгосон опционы тооцоолсон бодит үнэ цэнэ 2017 оныхоос бага байгаа юм.

	6-р сарын 30-наар дуусгавар болсон 3 сарын хугацаанд		
	2018 он	2017 он	Өөрчлөлт
Захиргаа үйлчилгээ	\$ 270,652	\$ 343,274	\$ (72,622)
Элэгдэл хорогдол	3,053	3,364	(311)
Захирлуудын төлбөр, зардал	75,142	84,962	(9,820)
Хөрөнгө оруулагчидтай харилцах, маркетинг	90,149	190,670	(100,521)
Оффисийн болон бусдаажил	64,166	57,637	6,529
Мэргэжилтний хөлс	117,978	74,238	43,740
Эрх зүйн нийцлийг хангах	86,803	76,928	9,875
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	536,977	817,621	(280,644)
Унаа, байр	33,127	76,498	(43,371)
	\$ 1,278,047	\$ 1,725,192	\$ (447,145)

Улирлын үр дүнгийн хураангуй

Хувьцааны тоо хэмжээнээс бусад дүнг мянган Канад доллараар илэрхийлэв.

Санхүүгийн жил 2018		Санхүүгийн жил 2017				Санхүүгийн жил 2016			
2-р улирал 6-р сар	1-р улирал 3-р сар	4-р улирал 12-р сар	3-р улирал 9-р сар	2-р улирал 6-р сар	1-р улирал 3-р сар	4-р улирал 12-р сар	3-р улирал 9-р сар		
Ашиг		Nil	Nil	Nil	Nil	Nil	Nil	Nil	Nil
Цэвэр алдагдал		\$1,439	\$702	\$649	\$713	\$2,069	\$596	\$492	\$73
Нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан алдагдал		\$0.01	\$0.00	\$0.00	\$0.01	\$0.02	\$0.00	\$0.00	\$0.00
Нийт актив		\$19,500	\$14,879	\$14,946	\$15,592	\$16,730	\$17,208	\$4,293	\$3,872

Корпораци нь 2017 оны мөн үеийн нэгж хувьцаанд ногдох алдагдал \$0.02 доллар буюу \$2,664,797 байсантай харьцуулахад 2018 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хугацаанд нэгж хувьцаанд ногдох алдагдал \$0.01 доллараар буюу цэвэр алдагдал \$2,141,134 доллар болж буурсан.

Корпорацийн зардал Монгол дахь хайгуулын хөтөлбөрүүдээс хамаарч улирал тутам харилцан адилгүй байна. Корпораци нь өнгөрсөн хугацаанд санхүүгийн үр дүнд нөлөөлөх хэлбэлзэл үүсгэж болохуйц тодорхой чиг хандлагын тухай мэдээлэл аваагүй болно.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ба капитал нөөц

Энэхүү УХДШ гарах өдрөөр Корпорацийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор \$3.95 сая байна.

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 8-нд \$4.12 сая долларыг хаалттай санхүүжилт хэлбэрээр босгосон. Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 14-нд Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр давхар бүртгэл хийлгэн \$1.36 сая долларын хөрөнгө олон нийтээс татан төвлөрүүлсэн.

Корпораци нь 2017 оны 2 дугаар сарын 23-нд энгийн хувьцааг тогтсон үнээр худалдан авах хаалттай хэлцлийг хааж, \$13.8 сая долларын хөрөнгө оруулалт босгосон. Корпораци нь 2017 оны 3 дугаар сарын 20-нд Тек компанитай \$500,000 долларын брокерын бус хаалттай хэлбэрийн санхүүжилтийг хаасан (гаргасан нийт энгийн хувьцааны талаарх дэлгэрэнгүйг Эргэлтэд буй хувьцааны мэдээллээс үзнэ үү).

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийг Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төслүүдийг хөгжүүлэх, тэдгээр хөтөлбөрүүдийг дэмжих захиргааны болон нэмэлт зардлуудыг санхүүжүүлэхэд (Төслийн хураангуй болон Үйл ажиллагааны хэлэлцүүлгээс танилцана уу) зарцуулсан.

Одоогийн эргэлтийн хөрөнгөөр Корпорацийн төсөвт зардлуудыг 2019 оны 1-р улирал хүртэл санхүүжүүлэх юм. Цаашид Корпораци нь хөрөнгө борлуулах замаар нэмэлт хөрөнгө баталгаажуулах, түншлэл байгуулах, опционы ба/буюу хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах, хувьцааны санхүүжилт хийх ба/буюу зардал бууруулах зэргээр хайгуулын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх боломжтой. Нэмэлт санхүүжилт татах хугацаа, боломж, төлөвлөлт нь Корпорацийн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаар тодорхойлогдоно.

Корпорацийн орлогын эх үүсвэр хязгаартай тул мөнгөн гүйлгээнд дүн шинжилгээ хийх эсхүл ямар нэгэн бодитой чиг хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй. Корпораци нь хайгуулын болон төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүдээ хувьцаат капитал гаргах замаар санхүүжүүлж байна.

Энд дурдсанаас бусад байдлаар Корпораци нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, урьдчилан харж болохуйц ирээдүйд капитал хөрөнгө материаллаг байдлаар өсөх буюу буурах аливаа чиг хандлага, шаардлага, үүрэг, үйл явдал, тодорхой бус байдлын талаар мэдээлэл байхгүй болно. Корпорацийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, капитал хөрөнгийн өсөлт, бууралт нь Корпорацийн Монгол дахь

хайгуул, төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүд амжилттай эсвэл амжилтгүй хэрэгжих, мөн хангалттай хэмжээний хувьцааны санхүүжилт хийх чадвартай байх эсэхээс хамаарч тодорхойлогдоно.

Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл

Гаргасан болон эргэлтэд буй хувьцаат капитал

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 8-нд брокерын бус энгийн хувьцааны хаалттай хэлбэрээр \$4.12 сая долларын санхүүжилт татан төвлөрүүлсэхдээ нэгж үнэ нь \$0.38 доллар бүхий нийт 10,834,580 нэгж хувьцааг гаргасан. Нэгж бүр Корпорацийн нэг энгийн хувьцаа, нэг варрантаас бүрдэнэ. Варрант бүр нь тухайн нэгж хувьцаа эзэмшигчдэд хаалтын өдрөөс хойш 30 сарын хугацаанд Корпорацийн нэг энгийн хувьцааг \$0.60 доллараар худалдан авах эрхийг өгнө. Корпораци нь хаалттай хэлбэрээр хувьцаа арилжаалахтай холбогдуулан зуучлагчийн хөлсөнд нийт \$182,400 доллар төлж, 480,000 зуучлалын варрант гаргасан. Зуучлагчийн варрант бүрийг хаалтын өдрөөс хойш 30 сарын сарын хугацаанд нэг хувьцааг \$0.60 доллараар худалдан авахад ашиглаж болох ба олгосон өдрөөр зуучлалын варрантын бодит үнэ цэнэ \$1,357,750 доллар (нэг баталгаа \$0.12 доллар) байна. Хаалттай хэлбэрээр арилжаалахтай холбогдуулан гаргасан бүх үнэт цаасыг хаалтын өдрөөс хойш 4 сарын хугацаанд царцаана.

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 14-нд Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр давхар бүртгэл хийлгэн энгийн хувьцааг арилжаалан, \$1.36 сая долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн. Ингэснээр Корпораци нь МХБ дэх анхны давхар бүртгэлтэй компани болсон. Энэхүү хэлцэл гүйлгээгээр Корпораци нэгж нь \$0.34 долларын үнэ бүхий 4,000,000 энгийн хувьцаа гаргасан. Андеррайтеруудад нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 7% болох \$95,200 долларын төлбөр төлсөн. МХБ-ээр нийтэд хувьцаа санал болгох үйл ажиллагаа 2018 оны 6 дугаар сарын 19-нд эхэлсэн. Монгол Улсын өнөөгийн хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын эрх баригчид хил дамнасан арилжааг зөвшөөрөх хүртэл буюу бүртгэлээс хасах хүртэл дурьдсан 4,000,000 хувьцааг зөвхөн МХБ-ээр дамжуулан арилжаална. Түүнчлэн Монгол улсад нийтэд санал болгосон бүх хувьцааг Монгол дахь арилжаа хаагдсанаас хойш Канад улсад 4 сарын хугацаанд царцаана.

Корпораци нь 2017 оны 2 дугаар сарын 23-нд энгийн хувьцааг тогтсон үнээр худалдан авах хаалттай арилжааг хаан, \$13.8 сая долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн. Арилжааг Парадигм Капитал Инк. Канаккорд Женуйти Корп.-тай нэгдэн (хамтад нь “Андеррайтер” гэх) тэргүүлсэн. Корпораци нь нэгж үнэ нь \$0.77 долларын нийт 17,922,077 энгийн хувьцаа нэмж гаргасан ба үүнд Андеррайтерууд 15% нэмэлт хувьцаа гаргах эрхээ бүрэн хэрэгжүүлсэн. Андеррайтеруудын үзүүлсэн үйлчилгээнд нийт орлогын 6% болох \$828,000 долларын төлбөрийг, хувьцаа санал болгосны дагуу гаргасан хувьцааны 6%-тай тэнцэх 1,075,324 нөхөн төлбөрийн опцион олгосон. Нөхөн төлбөрийн опцион эзэмшигч нь 2019 оны 2 дугаар сарын 22-ныг хүртэл нэг хувьцааг \$1.20 доллараар худалдан авах эрхтэй байна.

Корпораци нь Тек компанитай 2017 оны 3 дугаар сарын 20-нд нэгж хувьцаа нь \$0.92 долларын үнэ бүхий 543,478 ширхэг хувьцаа гаргах брокерын бус санхүүжилтийг хаалттай хэлбэрээр хийн, \$500,000 долларын хөрөнгө оруулалт төвлөрүүлсэн.

Энэхүү УХДШ гарах өдрийн байдлаар Корпорацийн гаргасан болон эргэлтэд буй хувьцааны тоо 161,775,791 байна.

Хувьцааны опцион

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хугацаанд тодорхой албан тушаалтнууд, захирлууд болон ажилтнууддаа 3,060,000 опцион олгосон.

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хугацаанд нэгж хувьцааг дунджаар \$0.18 доллараар үнэлж, 978,125 ширхэг хувьцаа худалдаж авах опцион хэрэгжүүлж, нийт \$174,250 доллар олсон.

Энэхүү УХДШ гарах өдрийн байдлаар Корпораци нь \$0.42 долларын дундаж үнэтэй, бүгд хэрэгжүүлж болохуйц эргэлтэд буй хувьцааны 11,785,625 опционтой байна.

Нөхөн төлбөрийн опцион

Дээр дурдсан Хувьцааны опцион болон Гаргасан болон эргэлтэд байгаа хувьцаа хэсэгт илүү

дэлгэрэнгүй тайлбарласан Парадигм Капитал компанитай хамтран хийсэн санхүүжилтээс гадна Корпораци нь 1,075,324 ширхэг нөхөн төлбөрийн опцион гаргасан. Нөхөн төлбөрийн опцион эзэмшигч нь 2019 оны 2 дугаар сарын 22-ныг хүртэл нэг хувьцааг \$1.20 доллараар худалдан авах эрхтэй ба тус опционы бодит үнэ цэнэ \$322,597 доллар (нэгж нөхөн төлбөрийн опционы үнэ \$0.30 доллар) байв.

Энэхүү УХДШ гарах өдрийн байдлаар Корпораци нэгжийн үнэ \$1.20 долларын бүгд хэрэгжихүйц эргэлтэд буй 1,075,324 нөхөн төлбөрийн опционтой байна.

Ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцаа

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хугацаанд тодорхой албан тушаалтнууд, захирлууд болон ажилтнууддаа жигнэсэн дундаж үнэ нь \$0.40 долларын нийт 218,814 ширхэг ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцаа (DSU) олгосон.

Энэхүү УХДШ гарах өдрийн байдлаар Корпораци нь хувьцаагаар тооцогдох 3,629,000 ширхэг ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцаатай байна.

Төслийн товч танилцуулга

Корпорацийн алтны төслүүд нь дэлхийн хамгийн том алт, зэс-алтны ордууд байрладаг Төв Азийн Ороген бүслүүрт харьяалагддаг Монголын Эдрэнгийн террейнд оршдог. Хятадын хил даваад, мөн баруун зүг дагуух эпитеpmаль алт, порфир зэс-алтны ордууд сайтар судлагдсан байдаг хэдий ч 1990-ээд оныг хүртэл газар зүйн хувьд алслагдмал байдал, улс төрийн нөхцлөөс болж Монголд, ялангуяа Монголын баруун өмнөд хэсэгт хайгуулын судалгааны ажлууд хязгаарлагдмал тоотой хийгджээ. Монголын баруун өмнөд хэсэгт хийсэн хайгуулын ажлын дүнд 60 сая гаруй унц алт агуулсан дэлхийн хэмжээний Оюу толгой алт-зэсийн ордыг нээн илрүүлсэн байдаг. Сүүлийн арваад жилийн турш Эрдэнэ Ресурсын хайгуулын ажлаас бусдаар Монголын баруун өмнөд хэсэгт бүсийн хэмжээний системтэй эрэл хайгуул ховор хийгдсэн. Эрдэнэ Ресурсын хийсэн хайгуулын дүнд Баян Хөндий, Алтан Нар, Алтан Сум төслүүдэд ойролцоогоор 25 км гаруй суналтай алт, зэсийн хэд хэдэн илэрц бүхий алтны нэгэн шинэ бүсийг (Хөндий бүс) нээж илрүүлсэн. Орчин үеийн хайгуулын хувьд дөнгөж эхлэл шатандаа явж буй хэдий ч Хөндий бүс нь зэс-алтны порфир, дундлаг сульфидтэй карбонат суурь металт алтны орд, бага сульфидтэй эпитеpmаль алт болон алт-мөнгөний систем бүхий суурь болон үнэт металлын систем болох нь тогтоогдсон.

Тухайн бүс дэх Корпорацийн тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэж буй хайгуулын ажлын товч танилцуулгыг дор тусгав.

Баян Хөндий алтны төсөл

Баян Хөндий ("Rich Valley") алтны төсөл нь 4,514 га талбайг хамран, Монголын баруун өмнөд хэсэгт Эрдэнийн 100% эзэмшдэг Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд, Корпорацийн Алтан Нар алт-полиметаллын төслөөс урагш 16км-ийн зайд байрладаг. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь 12 жилийн 9 дэх жил дээрээ явж байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуульд заасан шаардлагыг хангаснаар 12 дахь жил дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой.

Нээлт ба ордын төрөл

Эрдэнэ Ресурс 2015 оны 2 дугаар улиралд Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хийсэн тандалтын судалгаагаар нээн илрүүлсэн бага сульфидтэй эпитеpmаль алтны систем болох Баян Хөндийд өдгөө Страйкер бүс, Алтан толгой бүс хэмээн нэрлэгдэх болсон талбайн гадаргын чулуулгаас анх авсан дээжийн 20%-аас 3.0 г/т давсан (4,380 г/т хүртэлх алт) хэмжээний алт илэрсэн. Корпораци нь өнөөгийн байдлаар хойд, баруун, зүүн зүгт тэлэх боломжтой, 400 метрийн өргөн, 1.3 км гаруй урт талбайтай 6 салангид (Страйкер, Мидфийлд, Хойд Мидфийлд, Алтан толгой, Баруун Страйкер, Зүүн хойд бүсүүд) бүсүүдэд алтны хүдэржилт байгааг олж тодорхойлоод байна. Боломжит гүний хувьд 2018 оны 1-р улиралд Корпорацийн мэдэгдсэн 2200 г/т алтны огтлолцол нь одоогоор мэдэгдэж байгаа хамгийн өндөр алтны агуулга бүхий хамгийн гүн огтлол юм. Шинээр тодорхойлсон Баруун Страйкер бүсэд хийсэн өрөмдлөгөөр гүндээ нээлттэй хувирмал чулуун агуулагч дотор алтны өндөр агуулгыг огтолж байгааг илрүүлсэн. Түүнчлэн Баян Хөндий системийн зүүн хойд хязгаарын талбайд хийсэн судалгаагаар гүндээ хувирч, эрдэсжсэн агуулагч чулуулагт нээлттэй тархсан байгаа нь тогтоогдсон. Тус орд нь багаас дундлаг агуулгатай алт агуулсан, цахиуржсан, иллитээр хувирсан Девоны галт уулын чулуулагт

агуулагдах структурын хувьд хяналттай, өндөр агуулгатай алтны судлуудаар тодорхойлогддо. Энэ Девоны агуулагч чулуулаг нь газрын гадарга дээр өгөршлийн 2 цонх байдлаар Цэрд болон Дөрөвдөгчийн хучаас хурдас доороос ил цухуйн гарсан байдаг.

Баян Хөндий нь Хишикари (Япон), Купол (Орос) болон Раунд Маунтэйн (АНУ) зэрэг дэлхийн бага сульфидтэй ордуудтай ижил төстэй бүтэцтэй байдаг.

Өрөмдлөгийн хураангуй дүгнэлт

Корпораци нь 2015 оны 4-р улиралд анхны цооногоо өрөмдсөнөөс хойш 2018 оны 2-р улирлын өрөмдлөгийн дүнг танилцуулах хүртэл хугацаанд Баян Хөндийд нийт 42,656 метр бүхий 255 алмазан цооног (45-90 градусын өнцгөөр) өрөмдлөө. Эдгээр цооногуудын ихэнх нь алтны аномаль хүдрийг огтолсон бөгөөд цооногуудын 20% нь 1 метрийн интервалд тонн тутамд нэг унцаас их алтны интервалыг огтолж байгаа юм.

Страйкер бүс

Баян Хөндийн анхны цооногийг 2015 оны 4-р улиралд Страйкер бүсэд (хойд Страйкер бүс, ВКD-01 цооногт 14 метрийн гүнд 27.5 г/т алтны агуулгатай 7 метрийн зузаантай интервал) өрөмдсөн. Үүнээс хойш Баян Хөндийн хүдэржилтийн өндөр агуулгатай шинж чанарыг илтгэн харуулахуйц 10 г/т алтны агуулга бүхий ойролцоогоор 70%-ийн огтлолцсон интервалтай 60 гаруй цооногийг Страйкер бүсэд өрөмдөөд байна. Корпораци нь алтны маш өндөр агуулгатай (жишээ нь: цооног ВКD-77: 306 г/т алтны агуулгатай 1 метрийн зузаантай интервал), өргөн бүс (ВКD-17: 5.3 г/т алтны агуулга бүхий 63 метрийн зузаантай интервал) болон түүнийг хүрээлсэн арай бага агуулгатай өргөн интервалууд (ВКD-51: 1.2 г/т алтны агуулгатай 112 метрийн зузаан интервал) зэрэг тогтвортой үргэлжилсэн, газрын гадаргад ойр алтны өндөр агуулгатай хэд хэдэн бүсийг илрүүлээ.

Баруун страйкер бүс

Корпораци нь Страйкер бүсийн баруун хэсэгт хоорондын зай нь 20-80 метр, нийт 27 цооногийг 375 x 250 метр талбайд өрөмдсөн. Цооногуудын босоо гүн нь 97-340 метрийн хооронд хэлбэлзэх бөгөөд дундаж гүн нь 223 метр байна. Эдгээр 27 цооногийн 26 нь алтны хүдэржилтийн аномаль утга бүхий хэсгүүдийг огтолсон. Үүний 13 нь алтны их өндөр агуулгатай буюу 10 г/т-с илүү агуулгыг огтолсон. 2017 оны 4-р улиралд Корпораци нь 3 цооногийн (ВКD-219 – ВКD-221) үр дүнг мэдээлсэн ба үүнд Страйкер бүсээс баруун тийш 250 метр зайд байх ВКD-220 цооногт огтлогдсон 116 г/т алтны агуулгатай 1 метрийн зузаантай интервал агуулсан дунджаар 9.2 г/т алтны агуулга бүхий 15 метрийн зузаантай интервал гэх зэрэг үр дүнгүүд багтаж байна. Дээрх үр дүн нь энэ бүсэд огтлогдсон хамгийн өндөр агуулга юм. Мөн нэмэлт өндөр агуулгатай бүсүүд Баруун Страйкерт байх боломжтойг харууллаа.

Страйкер-Мидфийлд холбоос

2017 онд Корпораци нь Мидфийлд болон Страйкер бүсүүдийн хоорондох хэсэгт, Страйкер бүсийн хойд хязгаарын дагуу 40 метрт төвлөрсөн хэд хэдэн алтны өндөр агуулгатай бүсүүдийг шалгахар өрөмдсөн. Нэмэлт цооногуудыг 2017 оны 3 болон 4-р улиралд гүйцэтгэсэн ба үүнд өмнө нь өрөмдсөн цооногуудыг сунган өрөмдлөө. Үүгээр Страйкер болон Мидфийлд бүсүүдийн хооронд алтны хүдэржилт үргэлжилж буйг баталсан бөгөөд ВКD194 цооногт дунджаар 3.3 г/т алтны агуулга бүхий 22 метрийн зузаан интервал, дунджаар 1.1 г/т алтны агуулгатай 128 метр зузаан интервал бүхий хүдэржсэн өргөн бүс огтлогдсон зэрэг үр дүнгүүд багтаж байна. Саяхны өрөмдлөгийг Страйкер болон Мидфийлд бүсийн хооронд гадаргад ойр, өндөр агуулга бүхий бүсийг шинээр тогтоох зорилгоор хийсэн. 2017 оны 4-р улиралд зарласан ВКD-222 цооног нь 50 метрийн гадаргууд 139 г/т хүртэлх алтны агуулгатай 1 метрийн дээжийг огтолсон, үүнд 6.7 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал багтсан. Энэхүү огтлолцолын өмнөд болон хойд хоёр цооногоос (ВКD-153 ба ВКD-86) мөн л 50 метрийн өргөн гадаргууд хүдэржилтийн өргөн интервалын хүрээнд 94.8 г/т, 31.4 г/т алтны агуулга бүхий дээж тус тус авсан. 2017 оны хайгуулын улирал эхлэхээс өмнө Страйкер, Мидфийлдийг тусгаарлаж буй 200 метрийн өргөн бүсэд хязгаарлагдмал өрөмдлөг хийсэн.

Мидфийлд бүс

Мидфийлд бүсийн хүрээнд хийсэн өрөмдлөгөөр алтны хүдэр агуулсан талбайг өмнөд хэсэг хүртэл доош уналтайгаар тэлж, Мидфийлдийн төв талбайн орчимд өмнө мэдэгдсэн тогтвортой үргэлжилсэн алтны өндөр агуулгыг бататгасан. Сүүлийн үр дүнгээр 42 метрийн гүнд 51 г/т алтны агуулга бүхий 8 метрийн зузаан интервал (ВКD-98 цооног), 6.0 г/т алтны агуулга бүхий 80 метрийн зузаан интервал,

6.1 г/т алтны агуулга бүхий 56 метрийн зузаан интервал (BKD-99 цооног); 1.8 г/т алтны агуулга бүхий 131 метрийн зузаан интервал, үүнд 8.2 г/т алтны агуулга бүхий 17 метрийн зузаан интервал (BKD-150 цооног); 7 метрийн 34.4 г/т алтны агуулга бүхий интервал агуулсан 2.6 г/т алтны агуулга бүхий 143 метрийн зузаан интервал (BKD-244 цооног) зэргийг илрүүлээд байна. Эдгээр үр дүнгүүд нь Мидфийлд бүсэд гидротермаль үйл ажиллагаа хамгийн эрчимтэй бөгөөд алтны хүдэржилт хамгийн ихээр агуулж байгаа гэсэн ажиглалтыг дэмжиж өглөө.

2017 оны 4-р улиралд хийсэн Мидфийлд бүсийн өрөмдлөгийн ажил нь бүсийн хойд хязгаарыг Зүүн Хойд бүс рүү чиглүүлэн тэлэхэд төвлөрч байсан ч шинээр зүүн зүгт тэлж чадсан. Мидфийлд бүсийн зүүн хязгаараас зүүн тийш 80 метр-т орших BKD-210-р цооногт 1.8 г/т алтны агуулга бүхий 43 метрийн зузаан интервал, үүнд 44.8 г/т хүртэл алтны агуулга байгааг илрүүлсэн. Энэ нь Мидфийлд бүсийн зүүн хязгаарыг тэлж өгсөн бөгөөд дараагийн шатны өрөмдлөгийн ажил хийгдэх шаардлагатайг харуулж байна.

Хойд Мидфийлд бүс

Корпораци нь 2017 оноос хойш Мидфийлд бүсийн хойд хэсэгт хоорондоо 20-80 метрийн зайтай хэд хэдэн цооног өрөмдсөн. Эдгээр цооногийн дийлэнх нь цахиуржиж иллитээр хувирсан Девоны галт уулын алт агуулагч чулуулгийг огтолж, алтны хүдэржилтийг Мидфийлд бүсээс хойш 280 метр хүртэл тэлж, мэдэгдээд байсан залуувтар, хүдэржилтийн дараах хучдасын доорх хүдэржсэн өргөн бүсийн уртыг хоёр дахин нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд: 7.2 г/т алтны агуулга бүхий 20 метрийн зузаан интервалыг багтаасан 2.8 г/т алтны агуулга бүхий 108 метр (BKD-110); 25 метрийн 5.3 г/т алт агуулсан 2.9 г/т алтны агуулга бүхий 55 метрийн зузаан интервал (BKD-111); 18 метрийн 3.0 г/т алт агуулсан 1.5 г/т алтны агуулга бүхий 60 метрийн зузаан интервал (BKD-140); 19 метрийн 4.6 г/т алт агуулсан 1.6 г/т алтны агуулга бүхий 72 метрийн зузаан интервал (BKD-178); 9 метрийн 12.5 г/т алт агуулсан 3.3 г/т алтны агуулга бүхий 40 метрийн зузаан интервал (BKD-179); 9 метрийн 8.2 г/т алт агуулсан 2.1 г/т алтны агуулга бүхий 39 метрийн зузаан интервал (BKD-182); болон 3 метрийн 8.2 г/т алт агуулсан 1.5 г/т алтны агуулга бүхий 93 метрийн зузаан интервал (BKD-228) зэрэг багтана.

Корпораци нь 2018 оны 1-р улиралд дээрх талбайд урьд өмнө огтлолцсон өндөр агуулгатай интервалуудын гүний үргэлжлэлийг шалгах зорилгоор Хойд Мидфийлд бүсэд тавьсан хоёр цооногийн (BKD-231 болон BKD-232) үр дүнг танилцуулсан.

BKD-231 цооног нь 2,200 г/т алт болон 948 г/т мөнгөний агуулгатай 1 метр зузаан интервал, 158 г/т алттай 14 метрийн зузаан интервалыг 193 метрийн гүнд (босоо гүн: 140 метр) огтолсон. Алтны хүдэржилт нь жижиг мөхлөгтэй нүдэнд үзэгдэх алт байсан бөгөөд агуулагч нь олон үе шаттай үүссэн кварц-адуляр-спекуляритын судал болон гематитийн брекч байсан. Энэ хүдэржсэн 14 метр нь 118 метр гүнээс эхлэх бөгөөд 0.1-ээс 2.8 г/т алтны агуулга бүхий хүдэржилтийг 112 метр зузаан интервалаар огтлогдсон. Огтлогдсон өндөр агуулга нь энэ цооногоос хойш 30 метр зайд байх BKD-110 цооногийн 115 г/т алтны агуулга бүхий 1 метр, 108 г/т алтны агуулга бүхий 1 метр, мөн цооногоос баруун хойш 30 метр зайд байх BKD-111-р цооногийн 44 г/т алтны агуулга бүхий 1 метр болон 33 г/т алтны агуулга бүхий 1 метрийн зузаан интервал зэрэг өндөр агуулга гүндээ үргэлжилж байгааг баталж өгсөн. Энэхүү өндөр агуулгатай судлуудыг олж нээснээр 2018 онд талбайн энэ хэсэгт нэмэлт, нарийвчилсан өрөмдлөгийн ажил хийх шаардлагатай болсон.

BKD-232-р цооногийг BKD-231-р цооногоос хойд зүгт ойролцоогоор 65 метр, Мидфийлд бүсээс хойд зүгт 100 метр зайд өрөмдсөн. Энэ талбайг урьд нь 80 метрийн тороор өрөмдөн, харьцангуй бага агуулга илэрч байсан. Уг цооног нь 10 г/т алтнаас илүү өндөр агуулгатай хэд хэдэн хүдэржсэн хэсгүүдээс бүрдэх 8.3 г/т алтны агуулга бүхий 22 метрийн интервалыг 90.5 (босоо гүн: 74 метр) метрийн гүнд огтолсон.

Хойд Мидфийлд бүсийн 2018 оны өрөмдлөгийн мэдээ

2018 оны 4-р сарын 11-нд эхэлсэн 2018 оны 2-р улирлын өрөмдлөгийн эхний дүнг Корпораци 2018 оны 5-р сарын 8-ны өдөр танилцуулсан. Энэ нь Хойд Мидфийлд бүсэд структурын өндөр агуулгатай бүсүүдийг турших, мөн энэ талбай дахь өндөр агуулга бүхий хүдэржилтийг тэлэх боломжийг турших зорилгоор тавьсан, нийтдээ 1,423 метрийн эхний 6 цооногийн дүн (BKD-235-BKD-240) юм. Алтны хүдэржилтийн баруун хил хязгаар дээрх хяналтын структур, хүдэржилтийн гол чиглэлтэй перпиндикуляр орших алт агуулагч хойноос урагш чиглэлтэй судлуудыг (108 градусын азимут) турших зорилгоор BKD-236 цооногийг тавьсан. BKD-239 болон BKD-240 цооногууд нь 5.6 г/т алт агуулсан 36.6 метрийн зузаан интервал BKD-232 (2018 оны 1-р улиралд тавьсан) гэх өмнө тавьсан цооногийн дэргэд хийсэн хэмжээст өрөмдлөгийн цооног юм.


Эдгээр цооногийн эхний үр дүнгээс харахад 6 цооног бүгд нүдэнд харагдахуйц алтны хүдэржилтийг огтолсон, туршилтаар 22-оос 168 г/т-ийн агуулгын хооронд байгаа нь Хойд Мидфийлд бүсэд өндөр агуулгатай хүдэржилт тогтвортой үргэлжилж байж болзошгүйг баталсан. Хойд Мидфийлд бүсийн цөм дэх туршилтаар маш өндөр агуулга буюу VKD-238 цооногос 168 г/т алтны агуулгатай 2 метрийг агуулсан 21.6 г/т алтны агуулгатай 18 метрийн зузаан интервал илэрсэн.

Бүх цооногууд 1 г/т-с их алтны агуулгатай 16-102 метрийн зузаан интервалыг бүсүүдийг огтолсон байна. Түүнчлэн өрөмдлөгөөр VKD-236 болон VKD-237 цооногт олон шатлалт кварц-хальцедоны судлууд болон брекчүүд огтлолцсон алт агуулагч тэжээлийн бүс байгааг баталгаажуулсан.


Зүүн хойд бүс

Корпораци нь Зүүн хойд бүсэд 600м x 400м талбайд 8 цооног тавьсан. Зүүн хойд бүсийн хамгийн өмнөд хязгаарт тавьсан VKD-122 цооногос (Мидфийлдээс зүүн урагш 500 метр) 65 метрийн гүнд 0.72 г/т алтны агуулга бүхий 21 метр болон 0.75 г/т алтны агуулга бүхий 14 метрий зузаан интервал огтолсон бөгөөд үүнд 4.4 г/т алтны агуулга бүхий 2 метрийн зузаан интервал багтсан. VKD-122 цооногос зүүн хойш 600 метрийн зайнаас авсан чөмгөн дээжээр 6.9 г/т болон 0.4 г/т алтны агуулга илэрсэн.

Баян хөндийн төлөвлөлтийн зураг ба хөндлөн огтлол



Баян хөндийн хөндлөн огтлол ба – Мидфийлд бүсээр баруун хойш харахад



Геологи

Узбекистан улсын баруун хязгаараас эхлэн Тажикстан, Киргизстан, Хятадын баруун хойд хэсгээр дайран Монголын баруун өмнөд хэсэгт хүрэх Төв Азийн Ороген бүслүүрт харьяалагддаг Монголын Эдрэнгийн нуруунд Баян Хөндий төсөл оршдог. Энэ бүслүүрт дэлхийн хэмжээний томоохон ордууд багтдаг. Үүнд Монголын зүүн өмнөд хэсэгт байрлах Рио Тинтогийн ("Rio Tinto") зэс-алтны Оюу Толгой орд, Киргизстанд байх Сентерра Гоулдын ("Centerra Gold") Кумтор алтны уурхайнууд орно.

Баян Хөндий нь Девоны галт уулын чулуулагт агуулагдах бага сульфидтай эпитеpmаль алтны ордын төрөлд хамаарагдана. Энэ Девоны агуулагч чулуулаг нь газрын гадарга дээр өгөршлийн 2 цонх байдлаар Цэрд болон Дөрөвдөгчийн хучаас хурдас доороос ил цухуйн гарсан байдаг. Энэ ил гарсан талбайнууд (гарш) нь хайгуулын талбайн урд талд байрлах ба тэдгээрийг Страйкер болон Алтан Толгой бүс, мөн Зүүн Хойд бүс гэж нэрлэсэн. Эдгээр бүсүүд нь дунджаар нийт хэтийн төлөвт талбайн 20%-тай тэнцэнэ. Энэ 2 гарш нь хоорондоо 600 метр зайтай байрладаг. Баян Хөндийд илрэх бүх туфлэг чулуулаг нь олон шаттай үүссэн цахиуржилт болон шаврын хувиралд хүчтэй орсон байдаг. Талбайд геологи, структур, петрограф, шаврын спектрийн болон ормын мөрийн судалгаануудыг хийсэн бөгөөд эдгээр судалгаанууд нь хүдэржилтийг бага сульфидтэй эпитеpmаль ордын төрөл болохыг харуулдаг. Алтны хүдэржилт нь агуулагч туфуудыг зүссэн кварц ± адулярын судлууд, кварцын брекчүүдтэй холбоотой гематит-спекуляритын судлууд, кварцын судлуудыг хүрээлэн эмжээрлэсэн хувирлын бүс, мөн ан цавыг дүүргэсэн гематит-спекуляритын хүдэржилттэй холбоотой байх хувирсан агуулагч чулуулагт тархсан байдаг. Алтны мөхлөгийн хэмжээ янз бүр байгааг олон цооногор тогтоогдсон. Ерөнхийдөө жижиг мөхлөгтэй байна. Цөөн цооногуудад маш жижиг мөхлөгтэй сарнисан пирит ажиглагдсан. Страйкер бүсийн баруун хойд хэсэгт байх BКD-32 гэх зэрэг цөөн цооногууд пиритээр баяжсаныг эс тооцвол, Баян Хөндий нь ерөнхийдөө сульфидын хүдэржилттэй байдаг.

Бие даасан зөвлөхүүд

Корпорацийн 2017 оны хайгуулын хөтөлбөрийн хүрээнд Баян Хөндийд чөмгөн дээжний болон гадаргын чулуун дээжийн спектрийн шинжилгээ, эпитеpmаль алтны системээр мэргэшсэн мэргэжилтний үнэлгээ, геофизикийн тайлал, структурын судалгаа, гурван хэмжээст загварчлал зэрэг хэд хэдэн хараат бус судалгааг хийлгэж, энэхүү судалгааг нэгтгэн хайгуулын төлөвлөлт, нөөцийн ангилалыг тогтооход чиглэсэн өрөмдлөгийн оновчтой арга барилыг судлан тогтоосон. Эдгээр судалгаанд дараах мэргэжилтнүүд оролцов. Үүнд:

- Оттавад төвтэй, эпитеpmаль алтны системийн дэлхийн тэргүүлэх мэргэжилтэн, хараат бус зөвлөх Др. Жэффри Хеденквист (Dr. Jeffrey Hedenquist) нь 2016 он болон 2017 оны 3-р улиралд Баян Хөндий төсөлтэй танилцаж, улмаар 2016 оны 3-4-р улирал болон 2017 оны 2-р улиралд хийгдсэн өрөмдлөгийн ажлын үр дүнг нягтлан, геологийн тайлал болон өрөмдлөгийн ажлын үр дүнг сайжруулахаар дахин 2017 онд Баян Хөндийд ажилласан.
- Голландад төвтэй, мэргэшсэн структур геологич, хараат бус зөвлөх Др. Армелле Клоппенбург (Dr. Armelle Kloppenburg) 2017 оны 3-р улиралд Баян Хөндий, Алтан Нар болон Алтан Сум төслүүдтэй танилцсан. Др. Армелле Клоппенбург геологи структурын цогц судалгааг Монголын баруун өмнөд хэсэгт байрлах Корпорацийн алтны төслүүдэд болон илүү өргөн металлогенийн бүсэд хийсэн. Үр дүнд нь алтны хүдэржилтийн хяналтын талаарх шинэ ойлголтыг бий болгосон бөгөөд тэрээр ирээдүйд өрөмдөж болох боломжит талбайнуудыг санал болгосон.
- Эпитеpmаль болон порфир системийн хувирлын судалгаагаар мэргэшсэн Плас Минералс ("Plus Minerals LLC") ХХК-ийн Др. Б.Хашгэрэл болон ноён Иманц Кавалерис (Imants Kavalieris) нар 2016 оны 3-4-р улирал болон 2017 оны 2-р улирлын өрөмдлөгийн ажлын чөмгөн дээжийг судлан, гидротермаль систем дэх хувирлын бүсүүдийг тодорхойлж, ирээдүйн өрөмдлөгийн талбайг ялгахад хувь нэмэр оруулсан.
- Шинэ Зеланд улсын Хэрэглээний Петрологийн Үйлчилгээ ба Судалгааны Төвийн ноён Антони Күүт (Anthony Coote) петрографийн судалгааг 2016 болон 2017 онуудад Баян Хөндийн чөмгөн дээжинд хийсэн. Энэ ажлын үр дүнд гидротермаль системийн орчин, алтны хүдэржилтийн тархацын хяналт болон ордын ерөнхий гаралзүйн тайлалыг хийхэд тус нэмэр боллоо.
- Өрөмдлөгийн оновчтой талбайг сонгоход туслах зорилгоор хүдэржсэн бүсүүдийн гурван хэмжээст загварыг Террэйн Геосайнс ("Terrane Geoscience Inc") компани хийсэн. Энэ загварчлалд геологи, өрөмдлөг, структур, спектр, геохими болон геофизикийн бүх мэдээллийг оруулсан.
- Зонге Интернэшнэлийн ("Zonge International") ноён Чэт Лайд соронзон болон цахилгаан хайгуулын (IP) өгөгдлийн бүх санг боловсруулсан ба чанарын хяналтыг хийж гүйцэтгэсэн.
- РангеПинкокМинарко Лимитэд ("RungePincokMinarco Ltd") нь нөөц тогтоох өрөмдлөгийн ажлаас урьтаж хамгийн тохиромжтой өрөмдлөгийн торны зайг сонгох зөвлөгөөг өгч, өнөөг хүртэл хийсэн бүх ажлын үр дүн дээр бие даасан дүгнэлт гаргасан.

Геофизик

Корпораци нь 2015 оны 4-р улирлаас 2017 оны 3-р улирлын хооронд Баян Хөндийн зорилтот 1.8 x 2.0 км талбайд хос туйлт (50 метрийн туйлт зайг ашиглан 100 метрийн тууш зайтай 29.4 тууш км) аргачлал ашиглан градиент өдөөгдөх туйлшралын (IP) хайгуул (100 метрийн тууш зайтай 2x2ки талбайд), газрын соронзон судалгаа (2.05x1.8 км талбайд 20 метрийн зайтай шугамууд) зэрэг геофизикийн цогц судалгааг хийж гүйцэтгэсэн. Өмнөх зураглал, геофизикийн судалгаанууд нь эрчимтэй хувирлын бүсүүдийн тэлэлт, Дөрөвдөгчийн хучдас дорх Страйкер болон Мидфийлд бүсээс өмнөдрүү болон хойш, зүүн хойш, зүүн тийш чиглэлтэй хүдэржилт байгааг баталгаажуулсан.

Градиент матриц өгөгдөл дэх эерэг эсэргүүцлийн хүчтэй аномаль (>1,000 ом метр) нь ил гарсан, эрчимтэй цахиуржиж, иллит-хувиралд орсон галт уулын чулуулагтай тун дөхсөн, эрчимтэй цахиуржилтийн шинжийг агуулсан гэхээр байв. Градиент матриц өгөгдлөөс ажиглагдсан өндөр хариу үйлдэлт эсэргүүцэл нь хувираагүй базальт хэмээн тэмдэглэгдсэн талбайд зүүн тийш хэдэн зуун метрээр тэлж, хувирлын бүс галт уулын хучдас доогуур тэлсэн болохыг харуулж байгаа нь соронзон судалгааны өгөгдөлтэй нийцэж, өрөмдлөгөөр баталгаажсан болно. Хоёр туйлт судалгааны өгөгдлүүд нь залуувтар Цэрдийн чулуулгийн доогуур урагш болон хойш чиглэлтэй өндөр эсэргүүцэлтэй хувирал тэлж байж болзошгүйг мөн харуулсан. Градиент болон хоёр туйлт судалгааг нэгтгэн үзвэл цахиуржсан бүс нь залуувтар хучдасын доогуур урагш болон хойш тэлсэн, харин Цэрдийн тунамал чулуулаг болон галт уулын чулуулгийн доогуур өмнө зүгт харьцангуй гүехэн (<100 метр) сунаж тэлсэн байдалтайгаар соронзон болон цахилгаан хайгуулын өргөн аномалийн оройд байрлаж байна. 2017 оны 2-3-р улиралд хийсэн өрөмдлөгөөр соронзон болон цахилгаан хайгуулын өндөр эсэргүүцэлтэй хоёр туйлын хайрын үйлдэл нь хүдэржилтийн дараах сиенитийн нэвчилтийг зааж байв.

Соронзон судалгааны өгөгдлөөс Баян Хөндийн геологийн шинж чанарыг харж болно. Нийт соронзон талбайн аналитик дохио гадаргад ойр чулуулгийн соронзон хариу үйлдлийг заах бөгөөд урагш болон хойш чиглэсэн кварц/иллитийн хувирал, хувираагүй базальтын бүс дэх соронзон гүрийн сарнилын нөлөөгөөр соронзон орны нам хариу үйлдэлтэй баруун өмнөд болон зүүн хойд талбайн хувирмал литологийн тархацыг илтгэнэ. Мидфийлд-Страйкер бүсийн хойд хэсгийн нам соронзон хариу үйлдэл бүхий өргөн талбайг гадаргын Цэрдийн чулуулаг дорх хүдэржилтийн дараа үеийн сиенитийн нэвчилт, эсхүл өргөн тархсан хувирлаас шалтгаалан соронзон үйлчлэл нь нэлээд сарнисан талбай гэж тайлбарлана. Эдгээр соронзон хүчний хариу үйлдэл багатай талбайн чулуулгийн төрлийг сүүлийн өрөмдлөгөөр баталгаажуулсан. Страйкер, Алтан Толгой болон Зүүн хойд бүсүүдийн ойролцоох соронзон хүчний дундаж хариу үйлдэл бүхий талбайг магнетит агуулсан, хүдэржилтийн дараах монзонитийн нэвчилт бүхий талбай гэж тайлбарлана.

Металлурги

Металлургийн хүндийн хүч болон цианидаар уусган боловсруулах технологийн судалгааг Баян Хөндийн анхны өрөмдлөгийн ажлын (газрын гадаргаас 50 метрээс илүүгүй гүнд өрөмдсөн 15 цооног) 2 дээжинд (24.9 г/т алттай - өндөр агуулгатай, 0.7 г/т алттай - бага агуулгатай дээжүүд) Бритиш Колумбын Парксвиллийн Блү Көүст Ресөрч ХХК (Blue Coast Research LLC, "БКР") хийж гүйцэтгэсэн. Өндөр агуулгатай дээжийг хүндийн хүчний аргаар сайн боловсруулахад металл авалт 71% байсан. Алтны хүндийн хүчний боловсруулалтын муруй шугамаас, алтны багавтар мөхлөгтэй хэсгүүд хүндийн хүчний аргаар боловсруулж болох их хэмжээний алттай болохыг илрүүлсэн. Өндөр агуулга бүхий дээжийн баяжмал нь дээжийн үндсэн жингийн 1.2%-тай тэнцэж байсан бөгөөд 1,381 г/т алт болон 200 г/т мөнгөний агуулгатай байсан. Хүндийн хүчний боловсруултаар бага агуулгатай дээж нь багаас дунд хэмжээний металл авалттай байсан.

Хүндийн хүчний аргаас гарсан хаягдалд буюу өндөр болон бага агуулгатай дээжүүдэд нь лонх эргэлтийн аргаар цианидын уусгалт хийсэн бөгөөд металл авалт аль алиных нь хувьд өндөр гарлаа (өндөр агуулгатай дээжинд 95%-тай ба бага агуулгатай 47 дээжинд 86%-тай). Хүндийн хүчээр баяжмал ялгах болон хүндийн хүчний хаягдлыг цианидын аргаар боловсруулах аргуудыг хослуулснаар нийт металл авалт маш өндөр гарсан ба өндөр агуулгатай дээжинд 99%, бага агуулгатай дээжинд 92% байна.

Энэ үр дүн нь Баян Хөндий нь бутлахад алтны чөлөөлөгдөх чадвар сайн, уламжлалт аргаар боловсруулт хийх бүрэн боломжтойг харуулж байна.

Корпораци нь металлургийн 2 дахь шатны судалгааг 2017 оны 2-р улиралд эхлүүлсэн ба үүнд өөр өөр агуулга бүхий дээжүүдийн боловсруулалт, бутлагдах шинж чанарын судалгаа болон нуруулдан уусгалтын аргууд багтсан болно. Баян Хөндийн анхдагч 2 дээжийн үр дүн нь бутлуураар бутлахад чөлөөлөгдөх алттай, уламжлалт аргаар боловсруулж болохыг харуулсан. ВК-16-03 (4.3 г/т алттай): 48 цагийн уусгалтын дараа металл авалт 96% байсан ба 96 цагийн дараа металл авалт 97%-тай болсон. Дээжийн 80% нь 60 микрон хүртэл бутлагдсан ба 40% хатуу, 1.0 г/л найрлагатай цианидын уусмалд хийсэн. ВК-16-04 дээжийн анхдагч агуулга нь 4.47 г/т байсан ба бүрэн хэмжээний цогц туршилтыг энэ дээж дээр хийсэн. Үүнд нунтгийн хэмжээ, уусгах хугацаа болон цианидын уусмалын тун зэргийг өөр өөрөөр тохируулан туршсан бөгөөд хүндийн хүчний боловсруулалт хийсэн тохиолдолд нийт металлын гарцыг дүгнэн үнэлсэн. Нунтгийн 80% нь 60 микроноор гарсан дээжийн 48 цагийн уусгалтын дараагаар металл авалт 91-93.4% байсан ба 96 цагийн дараагаар металл авалт 95%-тай болсон. ВК-16-04 дээжийн 80%-ийг 170 микрон хүртэл буталж, 40% хатуу, 1.0 г/л найрлагатай цианидын уусмалд 96 цаг

хийн цианын хүчлээр уусгах туршилт хийхэд 48 цагийн уусгалтын дараа металл авалт 94% байсан ба 96 цагийн дараа металл авалт 95%-тай болсноос үзэхэд 48 цагийн дотор металын дийлэнх хэсэг ялгарч гарч байна. Энэхүү туршилтыг ВК-16-03 дээжид ашигласнаас илүү бүдүүн хэмжээтэй бутлуур ашиглан гүйцэтгэсэн хэдий ч метал ялгаралтыг харьцуулахуйц байгаа нь хамгийн тохиромжтой бутлуурын хэмжээг тодорхойлох нэмэлт туршилт хийх хэрэгтэйг харуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Бутлагдах шинж чанар нь Бонд Род Милл Уорк Индэксийн 17.8 кВтц/т болон Бонд Болл Милл Уорк Индэксийн 16.1 кВтц/т гэж судалгаагаар тогтоогдсон. Хоёрдугаар шатны судалгааны ажил 2018 онд үргэлжлэх ба 1.5- 3 г/т хүртэлх агуулгатай дээжүүдэд голдуу хийгдэнэ.

Төслийн эрсдэлийг багасгах, хөгжүүлэлтийн замд бэлтгэх нь

Баян Хөндий, Алтан Нар алтны төслүүдийн тусгай зөвшөөрөл болон эдийн засгийн судалгаа хийх үйл явцад дэмжлэг болох үүднээс хэд хэдэн судалгааг хийж, гүйцэтгэсэн.

Суурь судалгаа

Цэнхэр Номин (Алтан нар) болон Хөндий (Баян Хөндий, Алтан Сум) тусгай зөвшөөрөлт талбайнуудад 2016 оны 5 дугаар сард Монголын Шинжлэх ухааны Академи, Монгол Улсын их сургууль тус тус палеонтологийн болон археологийн судалгаануудыг хийж гүйцэтгэсэн. Эдгээр судалгаа нь дээрх талбайд палеонтологи, археологийн ул мөр байгаа эсэхийг тодруулах зорилготой байв. Судалгааны албан ёсны тайланд хараат бус экспертүүдийн зүгээс палеонтологийн болон археологийн ямар нэг олдвор тэмдэглээгүй бөгөөд гадаргын ус ховор, бэлчээр байхгүйгээс тус талбайд хүн нутагшин амьдрах боломжгүй байсныг дурджээ.

Алтан Нар, Баян Хөндий төслийн байгаль орчин, нийгмийн суурь судалгаанд шаардагдах мэдээллийг 2016 оны 5 дугаар сараас эхлэн түүвэрлэсэн. Уул уурхайн төслүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий Монголын мэргэшсэн гэрээт гүйцэтгэгч болох Эко Трэйд ХХК нь хээрийн судалгаа, хоёрдогч эх сурвалжийн мэдээллийг нэгтгэсэн. Суурь судалгааны өгөгдөлд газар ашиглалтын нөхцөл, агаарын чанар, амьтан, ургамал, ус, соёлын өв, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал зэрэг гол сэдвүүдийг хамруулсан байна. Корпораци нь нэгтгэсэн анхдагч мэдээлэлд тулгуурлан ус, биологийн төрөл зүйл, газар ашиглалтын нөхцөл зэргийг гүнзгийрүүлэн судлуулахаар 2017 оны 7 дугаар сард Эко Трэйд ХХК-тай нэмэлт суурь судалгаа хийх гэрээ байгуулсан. Корпораци нь Алтан Нар, Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбай дахь ашигт малтмалын нөөцийг бүртгүүлэх Монгол Улсын эрх зүйн шаардлагыг хангах зорилгоор суурь судалгааг шинэчлэн хийлгэхээр гэрээлэгч компанитай хамтран ажиллаж байна. Одоо хийгдэж буй ажлын дүнд уурхай ашиглалтын төсөл хөгжүүлэлтийг эхлэхээс өмнө Монгол Улсын Засгийн газраас шаардаж буй газрын нөхцөл байдлын бүрэн хяналт шалгалтын (аудитын) тайлан гарах юм. Корпораци нь Алтан Нар болон Баян Хөндий төслүүдийн ирээдүйн уурхай ашиглалт, хөгжүүлэлтээс байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг удирдах олон улсын гүйцэтгэлийн стандартыг ханган ажиллахын тулд суурь өгөгдлүүдэд GAP шинжилгээ (Gap analysis) хийхээр төлөвлөж байна.

Эрчим хүч

Оюу толгойн зэс-алт боловсруулах үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч Монгол Улс үндсэн болон оргил ачааллын эрчим хүчээ хөрш орнуудаасаа авч байна. Корпорацийн зүгээс шинэ цахилгаан сүлжээний холболтоор дамжуулан Төвийн эрчим хүчний системээс цахилгаан татаж авах боломжийг судалж эхлээд байгаа. Тус судалгаа, үнэлэлт дүгнэлт нь ирээдүйн уурхай ашиглалтын төлөвлөгөөнд хэрэглэгдэх бөгөөд эрчим хүчний хангамжийн хамгийн боломжит шийдлийг эрт олж нэгдэх боломжийг Корпорацид бүрдүүлж өгөх юм.

Олон улсын санхүүгийн корпорацийн санаачилгаар Эрдэнэ Ресурс нь Алтан Нар, Баян Хөндий төслүүдийг сэргээгдэх эрчим хүчээр хангах хувилбаруудыг судлах ажилд оролцох, түүнийг хамтран санхүүжүүлэхээр болоод байгаа билээ. Сэргээгдэх эрчим хүчний хангамжийн судалгааны дүнд сэргээгдэх эрчим хүч ашиглах төслийн талбайн тодорхой кэйс урьдчилсан байдлаар гарч, Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад дөхөм болохуйц сэргээгдэх эрчим хүчний шийдлийг ирээдүйн уурхайд ашиглах боломжууд тодорхойлогдох юм.

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчи

Корпораци нь тусгай зөвшөөрлийн хугацаанд Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагын дагуу байгаль орчны менежментийг хэрэгжүүлнэ.

Энэ улиралд Корпорацийн албан хаагчид болон гэрээт ажилтнуудын дотроос амь нас эрсэдсэн болон хөдөлмөрийн чадвар алдалттай холбоотой ослын хэмжээ бүртгэгдээгүй байна.

Корпораци нь дотоодын байгаль орчны хяналт шалгалт зэрэг албан ёсны эрх зүйн сувгууд болон иргэд, олон нийттэй цаг үеийн асуудлаар ярилцах замаар орон нутгийн оролцогч талуудын оролцоог хангаж, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна.

Корпораци нь 2017 оны орон нутгийн амьжиргаа, суурь боловсрол, нийтийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн улсын болон орон нутгийн түвшний арав гаруй санаачилгыг дэмжин ажиллаж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигддаг Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлага ёсоор Корпораци нь олон нийтийн оролцоог хангах, Корпорацийн хайгуулын үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох, олон нийтийн хөгжилд сайн дураар оролцох зэрэг хамтын ажиллагааны хүрээг тодорхойлсон хамтран ажиллах гэрээг Баянхонгор аймгийн удирдлагатай байгуулаад байгаа билээ.

Гидрогеологи

Уурхайн болон боловсруулалтад ашиглах ирээдүйн усны нөөцийн хувьд Баян Хөндий болон Алтан Нар төслүүд нь Говь цөлийн бүсийн баруун хойд буланд оршдог хэдий ч Алтайн нуруунаас эх авсан хэд хэдэн томоохон сав газруудын баруун өмнөд хэсэг нь усны гүн давхарга үүсгэсэн байж болзошгүй. Корпорацийн зүгээс өмнө нь Баян Хөндийн зүүн хойноос ойролцоогоор 70км-т Зуун Мод молибдени-зэсийн төслийн флотацийн боловсруулалтын үйл ажиллагаанд өдөрт >50,000 тонн усаар хангах усны эх үүсвэр байгааг олж тогтоосон. Корпораци нь 2017 онд Монголын гидрогеологийн компанитай хамтран Баян Хөндий, Алтан Нар төслүүдийн ойр орчимд байх 2 сав газарт усны хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлсэн. Энэ ажилд хайгуулын боломжит цэгүүдийг тодорхойлоход ашиглагддаг геофизикийн өгөгдлүүд (VES болон TEM), өргөн зайтай өрмийн хэд хэдэн цооногуудыг ашигласан. Корпораци нь Алтан Нар төслөөс ойролцоогоор 15 км, Баян Хөндий төслөөс 32 км-ийн зайтай усны урьдчилсан (буюу таамаг) нөөц буйг амжилттай тодорхойлсон. Секундэд 57 литр ус гаргах боломжтой гүний усны нөөцийг Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2017 оны 12 дугаар сарын сүүлээр батласан. Шинээр олж тогтоосон усны нөөц нь дээрх хоёр төслийн боловсруулалтын үйл ажиллагааг хангахуйц байна гэж үзэж байна.

2018-2019 онд усны нөөцийг илүү сайн тодорхойлох, ус гаргах зөвшөөрлөө баталгаажуулах, ил уурхайн хөгжүүлэлтэд гадаргын усны үзүүлэх нөлөөг тодорхойлох ажлуудыг хийнэ. Монголын говь нутгийн иргэдэд ус ямар чухал болохыг ойлгож байдгийн хувьд Эрдэнэ Ресурс нь Олон улсын Санхүүгийн корпорацийн Усны менежментийн сайн дурын кодекст нэгдэж, төслийн талбайн ойр орчимд амьдарч буй малчдыг тогтмол дэмжсээр ирсэн. Түүнчлэн усны шинэ эх үүсвэр хайж, хөгжүүлэх чиглэлд аймгийн удирдлагуудтай хамтран ажилласаар ирлээ.

Геотехник/инженерчлэл

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий төслийн нөөцийн тооцоолол, эдийн засгийн урьдчилсан судалгаа, уурхайн тусгай зөвшөөрөл бүрдүүлэлт, геологийн загварчлал, төлөвлөлтийн чиглэлээр хэд хэдэн зөвлөх компанитай хамтран ажилласан.

Дүгнэлт

Корпораци нь 400 хүртэлх метрийн өргөнтэй, 250 хүртэлх метрийн гүнд 1.4 гаруй километр тархсан алтны хүдэржилтийг амжилттай тогтоогоод байна. Тус талбай нь тогтворжилт сайтай, гадаргад ил гарсан олон тооны алт агуулагч судлуудтай, судлуудын алтны агуулга маш өндөр (30 г/т-ээс их) гэдгээрээ онцлог. Эдгээр өндөр агуулга бүхий бүсүүд нь 10 дахь метр тутамдаа багаас дунд зэргийн агууламжтай цагиргаар хүрээлэгдсэн байдалтай оршино. Эдгээр онцлогт үндэслэн ил уурхайн хөгжүүлэлт бүхий үйлдвэрлэлтэй харьцуулахад харьцангуй өндөр агуулгатай алтны томоохон ил уурхай болно гэж Удирдлагын зүгээс үзэж байна. Корпораци нь Баян Хөндийн зэргэлдээх Алтан Нар төслийн саяхан шинэчлэгдсэн нөөцийн тайланг залгамжлан 2018 оны 3 дугаар улиралд Баян Хөндийн анхны нөөц тогтоолтыг хийлгэх ойрын зорилт тавин ажиллаж байна.

Баян Хөндийн мэдээллийн баталгаажуулалт, хайгуулын ажлын мэдээллийг Корпорацийн SEDAR-т байршуулсан дараах баримт бичгээс үзэх боломжтой. Үүнд:

- Монгол Улсын баруун өмнөд хэсэг, Баянхонгор аймаг, Баян Хөндий алтны төсөл (Хөндий хайгуулын тусгай зөвшөөрөл), Үндэсний стандарт 43-101 Техникийн тайлан”, Техникийн тайлан, 2018 оны 3 дугаар сарын 26. Корпорацаас Жилийн мэдээллийн тайландаа ашиглах зорилгоор боловсруулсан тайлан тул энд тогтоосон нөөцийн тайлан агуулагдаагүй болохыг анхаарна уу.
- 2017 оны 9 дүгээр сарын 12-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс компани Мидфильдийн хойд хэсэгт Шинэ бүс тогтоохоор үргэлжлүүлэн ажиллаж байна; Баян Хөндий алтны төсөлд 1.14 г/т алтны агуулга бүхий 120 метр зузаан интервал, үүний 3 метрийн зузаан интервалд 33 г/т алтны агуулга илэрсэн.”
- 2017 оны 9 дүгээр сарын 14-ний мэдээгээр, “Эрдэнэ Ресурс компанийн Баян Хөндий алтны төсөл металлургийн эерэг үр дүн үзүүлсэн” тухай танилцуулав.
- 2017 оны 10-р сарын 31-ний мэдээгээр, “Эрдэнэ компани Мидфильдийн зүүн хэсэгт 45 г/т алтны агуулга бүхий 1 метрийн зузаан интервал, түүнийг агуулсан 1.8 г/т алтны агуулга бүхий 43 метрийн зузаан интервал , Страйкерийн баруун хэсэгт 51 г/т алтны агуулга бүхий 1 метрийн зузаан интервал, түүнийг агуулсан 2.8 г/т алтны агуулга бүхий 20 метрийн зузаан интервал нэмж тогтоон Баян хөндийн хүдэржилтийн бүсийг тэлсэн” тухай мэдээлсэн.
- 2017 оны 12-р сарын 6-ны мэдээнд, “Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны төслийн Страйкер бүсэд 4.2 г/т алтны агуулга бүхий 61 метрийн зузаан интервал, Стайкераас баруун тийш 250 метрт хийсэн хэмжээст өрөмдлөгийн цооногос 9.2 г/т алтны агуулга бүхий 15 метрийн зузаан интервал огтлов” хэмээн тэмдэглэсэн.
- 2018 оны 1-р сарын 10-ны мэдээ, “Эрдэнэ Ресурсын Баян Хөндий алтны төсөлд хийсэн өрөмдлөгөөр хэд хэдэн өндөр агуулга бүхий бүсийг огтолсоноос 2,200 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал огтосон нь хамгийн өндөр агуулга боллоо”
- 2018 оны 5-р сарын 8-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс Баян Хөндий алтны төсөлд 21.6 г/т алттай 18 метр тогтвортой үргэлжилсэн өндөр агуулгатай бүс тогтоолоо”
- 2018 оны 6-р сарын 14-ний мэдээ, “Эрдэнэ Ресурсын Баян Хөндийд 4 метрийн 57 г/т алтны агуулгатай, 143 метрийн 2.6 г/т алтны агуулга бүхий хэд хэдэн өргөн интервал огтлогдов”
- 2018 оны 6-р сарын 14-ний мэдээ, “Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны төслийг 2.6 г/т алтны агуулга бүхий 81 метр зузаан интервалаар тэллээ. Үүнд 9.2 г/т алтны агуулгатай 17 метр зузаан интервал агуулагдаж байна. ”

Алтан Нар алт-полиметаллын төсөл

Алтан Нар (“Golden Sun”) төсөл нь Монголын баруун өмнөд хэсэгт орших Корпорацийн Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд, Баян Хөндий төслөөс баруун хойш 16 км зайд оршдог. Энэ хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилээр олгогддог хайгуулын тусгай зөвшөөрлийн ес дэх жилд хайгуул нь хийгдэж байгаа. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг 12 жилийн хугацаа дуусахаас өмнө хэдийд ч ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой байдаг. 4,669 га талбай бүхий Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийг Эрдэнэ Ресурс 100% эзэмшдэг.

Хураангуй

Эрдэнэ Ресурс нь сүүлийн 6 жилд явуулсан хайгуулын ажлын дүнд Алтан Нар нь томоохон хэмжээний, сульфидтэй алт-мөнгө-хар тугалга-цайрын эрдэсжилттэй, шинэ эпитеpmаль систем болохыг тогтоосон. Ялангуяа 2013 оноос 2016 он хүртэл хийгдсэн хайгуулын ажлаар буюу суваг малталтын ажил, гадаргуун геологийн зураглал, геохими болон геофизикийн судалгааны ажлууд болон олон шатлалт эрэл болон нөөц тогтоох өрөмдлөгийн ажил хийснээр хүдэржилттэй талбайг тэлж чадсан. Үүнд 5.6 x 1.5 км хүдэржилттэй корридор 18 алт-мөнгө-полиметаллын хэтийн төлөвт талбайг илрүүлсэн. Анхны нээлтүүд болох “Нээлтийн бүс” болон “Хойд Холбоос” бүсүүд нь хамгийн их судлагдсан талбайнууд юм. Газрын гадаргууд дөт гүнд өндөр агуулгатай энэ 2 бүс дээр 2015 оны 1-р улиралд NI 43-101-ийн нөөцийн урьдчилсан тайлангийн мэдээг гаргасан бөгөөд 2018 оны 5 сарын 10-нд нөөцийн тайланг шинэчлэн мэдээлсэн. (дэлгэрэнгүй мэдээллийг доороос үзнэ үү) Үлдсэн 16 дэд талбайн заримд нь өрөмдлөг огт хийгдээгүй, заримд нь анхан шатны өрөмдлөг хийсэн. Тэдгээр талбайнуудыг Эрдэнэ өндөр агуулгатай эрдэсжилттэй нэмэлт бүсүүд нээгдэх хэтийн төлөвтэй талбай гэж үзэж байгаа.

Корпораци нь 2017 онд Алтан Нар төсөл дээр 5,744 тууш метр өрөмдлөг хийсэн. Компани өмнө нь NI 43-101 ашигт малтмалын нөөцийн тооцоо хийсэн тухай дээр дурдсан. Түүнээс гадна шинэ боломжит талбайнуудыг шалган илрүүлэх, “Нээлтийн бүс” болон Хойд Холбоо талбайн ойр орчимд тэлэх өрөмдлөгийн ажлуудыг өргөжүүлэн гүйцэтгэсэн нь амжилттай болсон. Тэр дундаа 2017 оны 4-р улиралд зарлагдсан Нээлтийн бүсийн төв хэсэгт 20 метрийн зузаан интервал бүхий 10.3 г/т (TND-110) өндөр агуулгатай бүс огтлогдсон нь шинээр нээж олсон өндөр агуулгатай бүсийг цаашид тогтвортой өргөжүүлэхэд голлон анхаарсан.

Нээлт ба ордын төрөл

Алтан Нарыг Корпорацийн 2011 оны 3-р улиралд хийсэн бүс нутгийн эрэл болон зураглалын ажлаар нээн илрүүлсэн. Алтан Нар төслийг магма болон порфирын ордтой холбоотой, ихэвчлэн полиметаллаар баяжсан байдаг дундлаг сульфидтэй карбонат полиметалл алтны систем гэж тайлбарладаг. Энэ төрлийн алтны хүдэржилт нь зүүн өмнөд Азийн хамгийн эдийн засгийн үр ашигтай алтны хүдэржилтийн төрөлд хамаардаг бөгөөд Индонезийн Келиан уурхай (одоо хаагдсан боловч урьд нь Рио Тинто олборлолт хийж байсан) болон Папуа Шинэ Гвинейн Поргера алтны уурхай (Баррик Гоулд олборлолт хийж байгаа), мөн дэлхийн өөр бусад газруудад байх Эквадорын Фрута дэл Нортэ алтны уурхай (Лундин Гоулд Инк олборлолт хийж байгаа), Колорадын Крипэл Крик болон Виктор алтны уурхай (АнглоГоулд Ашанти Лимитэд олборлолт хийж байгаа), Руминий Росиа Монтана (Росиа Монтана Гоулд Корпораци олборлолт хийж байгаа) болон дэлхийн шилдэг 5 мөнгө олборлогч компанийн нэг Мексикийн Пенаскүйто (Гоулдкорп олборлолт хийж байгаа) зэрэг ордууд үүнд багтана. Энэ төрлийн орд нь ихэвчлэн брекчийн хоолойнуудтай (диатерм) холбоотой байдаг ба гүндээ 1 км-ээс ч илүү урт үргэлжилсэн байх боломжтой. Жишээлбэл, Келиан ил уурхайг 500 метр гүнд хүртэл олборлосон байдаг.

Өрөмдлөгийн хураангуй дүгнэлт – Нээлтийн бүс

Нээлтийн бүсэд өнөөг хүртэл хийсэн өрөмдлөгийн ажлаар энэ бүс нь хамгийн багадаа 500 метр урт сунасан болохыг илрүүлээд байна. Өрөмдсөн ихэнх цооног нь бага гүнтэйгээр (босоо гүн: <150м) суналын дагуу хоорондоо 20-100 метрийн зайтайгаар өрөмдөгдсөн. Тэдгээр нь алт, мөнгө, хар тугалга болон цайрын хүдэржилт босоо болон хажуу тийшээ үргэлжилж байгааг харуулсан. Хүдэржилт нь хойш-зүүн хойш чиглэлтэй, структурээр хянагдсан, босоо эгц уналтай эпитеpmаль брекчийн бүсүүдтэй холбоотой.

Корпораци нь сүүлийн 10 сарын турш Нээлтийн бүсийн өрөмдлөг хийгдээгүй байсан төв хэсэгт алтны өндөр агуулга бүхий интервал илрүүлсэн билээ. Энэ хүдэржилт нь гүн рүүгээ нээлттэй хэвээр үлдсэн. Энэ шинэ нээлт нь гол структуруудын огтлолцол дээр байрлах бөгөөд Нээлтийн бүс болон 5.6 км урттай “Алтан Нар”-ын хүдэржилтийн чиглэл дээр нэмэлт өрөмдлөг хийх шаардлагатайг үүнээс харж болно. Энэ нээлт нь 2015 оноос өмнөх ажил дээр үндэслэн хийгдсэн Нээлтийн бүсийн NI 43-101 нөөцийн тайлангийн дараа хийгдсэн нээлт юм. Мөн Нээлтийн бүсийн төв хэсэгт илрээд байсан бага агуулгатай интервалыг агуулсан дөт гүнд хийгдсэн өрөмдлөгийн үр дүнд тулгуурласан. Доорх хүснэгт нь 2016 оны 4-р улирал, 2017 оны 2-р улирал болон 2017 оны 3-р улирлуудад нээгдсэн өндөр агуулгатай шинэ бүсүүдийн үр дүнг харуулж байна.

Цооногийн дугаар	Бүртгэсэн огноо	Огтолсон гүн (м)	Интервал (м) (1)	Алт (г/т)	Мөнгө (г/т)	Зэс (%)	Хар тугалга (%)	Цайр (%)	Алтны дүйцэх нэгж (г/т) (2)
TND-90	2015.10.15	92 м	5.8 м	5.4	53.1	0.03	0.51	0.97	7.0
TND-101(3)	2016.12.19	96 м	15 м	52.3	125	0.69	2.49	2.87	56.9
TND-104	2017.5.20	133 м	8 м	6.21	91.6	0.04	1.15	1.29	8.84
TND-105	2017.5.20	100 м	14 м	7.92	43.7	0.23	0.67	1.16	9.52
TND-110	2017.10.10	97 м	20 м	10.3	37.5	0.13	0.79	0.93	11.8

(1) Тайланд дурьдсан интервалууд нь бодит зузаан биш болно. Одоогийн байдлаар хүдрийн биетүүдийн огторгуй дахь чиглэлийг тооцоолох хангалттай мэдээлэл байхгүй байна.

(2) Алтны дүйцэх нэгжийг зөвхөн алт, мөнгө, хар тугалга-цайрын агуулгуудыг дан ганц алтны агуулга хэлбэрээр дүрслэн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад учрах боломжтой металл алдалтыг тооцоогүй. Тооцооллыг ам. доллараар хийсэн ба ханшийг - алт \$1200/унц, мөнгө \$18/унц, хар тугалга ба цайр \$0.90/фунт гэж тооцсон.

(3) TND-101 цооног нь Нээлтийн бүсийн хүдэржилтийн чигт хэвгий өнцгөөр, геофизикийн судалгаагаар ажиглагдсан хөндлөн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад учрах боломжтой металл алдалтыг нэмэлт мэдээллийг Эрдэнэ Ресурсын 2016 оны 12-р сарын 19-ний мэдээнээс үзнэ үү (энд дар).

Үндсэн Нээлтийн бүсийн гадна талд хойноос зүүн хойш чиглэлтэй янз бүрийн зузаантай (53 метр хүртлэх үзэгдэх зузаантай) хагас босоо, 1 г/т-оос дээш алтны агуулга бүхий эрдэсжсэн бүсүүдийг

илрүүлсэн. Үүнд Нээлтийн бүсийн Хойд хүдрийн биетэд илэрсэн дунджаар 5.8 г/т алтны агуулга бүхий (7.8 г/т алтны дүйцэх нэгж (AuEq)) 19 метр интервал багтана. 2014 оны 4-р улиралд Нээлтийн бүсийн Хойд биетэд өрөмдсөн цооногт (TND-70) 11.4 г/т алтны агуулгатай (13.6 г/т AuEq) 8 метрийн зузаан интервал, түүнийг агуулсан 4.2 г/т алтны агуулга бүхий (5.1 г/т AuEq) 30 метр зузаан интервал илэрсэн. 2015 оны 10-р сард Нээлтийн бүсэд, цооног хооронд хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлын үр дүнг зарласан. Нээлтийн бүсийн Өмнөд биетэд өрөмдсөн TND-92-р цооног 9 метрийн зузаан интервалд 7.3 г/т алтны агуулгатай (9.2 г/т AuEq), түүнийг агуулсан 2.0 г/т алтны агуулга бүхий (2.8 г/т AuEq) 38 метр зузаан интервалыг 43-аас 81 метрийн гүнд огтолсон. Мөн Нээлтийн бүсийн Өмнөд биетэд өрөмдсөн TND-90-р цооног 2.0 г/т AuEq (1.4 г/т алт, 20 г/т мөнгө болон 0.68% хар тугалга болон цайр) бүхий 53 метр интервалыг 78- аас 131 метрийн гүнд огтолсон. Нээлтийн бүс нь зүүн хойд зүгт суналынхаа дагуу болон гүндээ нээлттэй байгаа.

2017 оны 2-р улирал – Нээлтийн бүсийн өрөмдлөгийн ажлын хураангуй

2017 оны 05-р сарын 30-нд Эрдэнэ Ресурс Нээлтийн бүсийн төв хэсэгт өрөмдсөн 6 цооногийн (нийт 1,326 тууш метр) мэдээллийг танилцуулсан. Эдгээр цооногууд нь 2016 оны 04-р улиралд илрүүлсэн алт-полиметаллын өндөр агуулга бүхий бүсийн үргэлжлэлийг баталгаажуулах зорилготой байсан. Эдгээр 6 цооногийг хүдэржсэн бүсийг зүүн урагш 45 градусын өнцгөөр өрөмдсөн. Үүнд TND-105-р цооногт 100 метр гүнд 9.5 г/т AuEq (7.9 г/т алт, 43.7 г/т мөнгө ба 1.83% хар тугалга болон цайр) бүхий 14 метрийн зузаан интервал, мөн TND-104-р цооногт 126 метр гүнд 3.1 г/т AuEq (2.2 г/т алт, 29.7 г/т мөнгө ба 0.76% хар тугалга болон цайр) бүхий 37 метрийн зузаан интервал (доорх хүснэгтийг харна уу) гэх зэрэг үр дүнгүүд багтаж байна. Энэ үр дүн нь Нээлтийн бүс дэх алт-полиметаллын хүдэржилт болон зэсийн агуулга нь гүн рүүгээ өсөх боломжтойг харуулж байна. Хүдэржилт нь гүн рүүгээ нээлттэй хэвээр байгаа.

2017 оны 3 ба 4-р улирал – Нээлтийн бүсийн өрөмдлөгийн ажлын хураангуй

Корпораци Нээлтийн бүс болон Нээлтийн бүсийн тэлэлт дээр хийсэн сүүлийн өрөмдлөгийн ажлаа 2017 оны 10-р сарын 12-нд тайлагнасан. TND-110-р цооногийн үр дүн нь Нээлтийн бүс дэх өндөр агуулгын тухай Эрдэнэ Ресурсын мэдэгдэхүүнийг өргөжүүлсэн бөгөөд энэ нь зэс зэрэг полиметалл болон үнэт металлын агуулгатай байх карбонат полиметаллын ордын загварыг баталгаажуулж байгаа юм. Доорх хүснэгтэд байх нөөцийн тайлангийн дараа илрүүлсэн алтны өндөр агуулгатай интервалуудаас гадна, цооног TND-110-т полиметаллын нэн өндөр агуулга илэрсэн, тухайлбал, 6.2% хар тугалга, 3.8% цайр, 0.85% хүртэл зэс агуулсан судлуудыг огтолсон. Нээлтийн бүсэд огтлогдсон өндөр агуулга бүхий үнэт болон полиметалл нь гүндээ нээлттэй. Энэ өндөр агуулгатай шинэ бүс нь доош гүндээ үргэлжлэх боломж өндөртэй. Үүнийг дараагийн нарийвчилсан өрөмдлөгийн ажлаар тодруулах болно.

Нийт 1,645м урт 8 цооногийг Нээлтийн бүсийн боломжит үргэлжлэлийн дагуу болон дагалдах структурууд дээр өрөмдсөн бөгөөд эдгээр бүх цооногууд нь хүдэржилтийн бүсийг амжилттайгаар тэлэн, дараагийн шатанд өрөмдөх талбайнуудыг тодорхойлж өглөө.

Нээлтийн бүсээс баруун хойш 100 метр зайд шинэ параллель структур нээгдсэн. Өрөмдсөн 2 цооногт (TND-113 болон TND-114) алт болон полиметаллын өндөр агуулга огтлогдсон. Үүнд 14.6 г/т алтны агуулга бүхий 1 метр, 2.4% цайр болон 3.8% хар тугалга агуулсан 79 метр гүнд байх 1.1 г/т алтны агуулга бүхий 20 метр интервал (TND-113), 91 метр гүнд байх 1.0 г/т алтны агуулга бүхий 17 метр хүртэл интервалууд (TND-114) багтаж байна.

Өмнө нь хийгдсэн өрөмдлөгийн ажлын үр дүнд Нээлтийн бүсийн хойд тэлэлт дээр хүдэржилт газрын гүндээ хойд зүг рүү унаж байгаа гэж тодорхойлогдсон бол шинэ хайгуулын цооногуудын үр дүнд энэ хүдэржилт зүүн хойд зүг рүү салаалж байгааг илрүүллээ. TND-111, TND-112, TND-116 болон TND-117 цооногууд алт-полиметаллын хүдэржилт огтолсон нь Нээлтийн бүсийн суналыг 150 метрээр тэлж, үүнээс TND-111-р цооног нь 1 метрийн 7.6 г/т Au, 37 г/т Ag, 3.3% Pb and 8.8% хүртэлх Zn агуулга ба TND-117 цооног нь 1 метрийн зузаан интервалд 0.6 г/т Au, 126 г/т Ag, 0.3% Cu, 3.6% Pb мөн 3.1% хүртэлх Zn агуулгыг тус тус огтолсон. Эдгээр өндөр агуулга бүхий судлууд нь цагаан мика хувиралтай өргөн бүсэд агуулагдах бөгөөд энэ бүс нь TND-111-р цооногт 0.41 г/т алтны эквивалент (0.2 г/т Au, 3 г/т Ag, 0.36% Pb-Zn) бүхий 145 метр зузаантайгаар, TND-116-р цооногт 0.53 г/т AuEq (0.4 г/т Au, 2 г/т Ag, 0.2% Pb-Zn) бүхий 145 метр зузаантайгаар илэрсэн. Эдгээр огтлолууд нь бүгд газрын гадаргуугаас 132 метрээс илүүгүй гүнд огтлогдсон.

TND-129 цооногийг 450 метрийн гүнтэйгээр (босоо гүн: 390 м) Нээлтийн бүсийн гүнд өрөмдсөн. Энэ цооног нь хэд хэдэн хүдэржсэн бүсийг дайрсан ба 382 метр гүнд (босоо гүн: 331 м) 2.7 г/т алт, 49 г/т мөнгө, 6.5% хар тугалга болон 2.2% хүртэлх цайрын агуулгатай 1 метрийн интервал огтолсон. Өмнө нь Нээлтийн бүсэд өрөмдсөн TND-31 цооногийг 2016 оны сүүлээр 190 м-ээс 450 метр хүртэл сунгасан.

Ингэснээр өмнө нь өрөмдөхөд илэрч байсан үнэт болон полиметаллын өндөр агуулга бүхий хүдэржилт илүү гүнд хүртэл үргэлжилж байгааг илрүүлэв. TND-31 нь 18.3 г/т AuEq бүхий 1 метрийн зузаан интервалыг 370 метр (босоо гүн: 320) гүнд, 6.9 г/т AuEq бүхий 1 метрийн зузаан интервалыг 401 метр (босоо гүн: 347 м) гүнд тус тус огтолсон.


Алтан нар төсөл -2 ба 3-р улирлын өрөмдлөгийн ажлын онцлох хэсгүүд

Цооног	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) (1)	Алт (г/т)	Мөнгө (г/т)	Хар тугалга (%)	Цайр (%)	Алтны дүйцэх нэгж (г/т)(2)
TND-103	139	169	30	0.25	3.2	0.26	0.49	0.68
TND-104	126	163	37	2.22	29.7	0.31	0.45	3.05
үүнд	126	142	16	3.65	50.5	0.63	0.77	5.13
үүнд	137	140	3	10.1	155	1.32	2.12	14.2
TND-105	100	114	14	7.92	43.7	0.67	1.16	9.52
үүнд	107	113	6	14.88	65.3	0.68	0.94	16.7
үүнд	111	112	1	40.0	87	1.72	1.87	43.2
TND-106	132	151	19	1.01	11.9	0.21	0.42	1.51
TND-108	120	145	25	1.29	16.6	0.51	0.76	2.20
үүнд	135	138	3	5.81	55.0	1.63	1.69	8.34
TND-109	162	170	8	2.71	10.6	0.11	0.32	3.09
TND-110	62	63	1	0.16	16	6.18	3.80	5.54
ба	97	117	20	10.3	37.5	0.79	0.93	11.8
үүнд	106	111	5	29.7	44.6	0.86	1.85	31.8
үүнд	106	107	1	101.0	84	2.01	3.26	105.0


(1) Тайланд дурьдсан интервалууд нь бодит зузаан биш болно. Одоогийн байдлаар хүдрийн биетүүдийн огторгуй дахь чиглэлийг тооцоолох хангалттай мэдээлэл байхгүй байна.

(2) Алтны дүйцэх нэгжийг алт, мөнгө, хар тугалга-цайрын холимог агуулгуудыг дан ганц алтны агуулга хэлбэрээр дүрслэн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад учрах боломжтой металл алдалтыг тооцоогүй. Тооцооллыг ам. доллараар хийсэн ба ханшийг - алт \$1200/унц, мөнгө \$18/унц, хар тугалга ба цайр \$0.90/фунт гэж тооцсон.

Нээлтийн бүсийн план зураг



Нээлтийн бүсийн дагуу зүсэлт (баруун хойш харж байгаагаар)



Өрөмдлөгийн ажлын дүгнэлт – Хойд Холбоо

Нээлтийн бүсээс гадна Алтан Нар дахь анхдагч нээлтүүдийн нэг нь Нээлтийн бүсээс хойш 1.3 км зайд орших Хойд Холбоо (ХХ) юм. Хойд Холбоод 8 суваг малтаж, хоорондох зай нь 50-200 метр байх 20 цооногуудыг өрөмдсөн. Үүний үр дүнд зүүн хойш – баруун урагш чиглэлтэй хүчтэй хувирсан хүдэржсэн өргөн параллель бүсүүд агуулсан структурт байх структурын тэлэлтийн бүстэй холбоотой хүдэржилт байгааг илрүүлсэн. Өмнөх өрөмдлөгийн ажлаар (2012) Хойд Холбоод өрөмдсөн ганц цооногт (TND-46) 5.4 г/т AuEq (4.4 г/т алт, 11.6 г/т мөнгө болон 1.7% хар тугалга цайр) агуулсан 9 метрийн зузаан интервал, түүнийг агуулсан 1.3 г/т алтны агуулга бүхий 47 метрийн зузаан интервал огтлогдсон. 2015 оны 3-р улиралд цооног хооронд өрөмдсөн нэмэлт өрөмдлөгийн ажлаар нөөцийн төв хэсэгт газрын гадаргад ойрхон хэд хэдэн өндөр агуулга бүхий хүдэржилт илрүүлсэн. Үүнд TND-82-р цооногт илэрсэн (газрын гадаргаас 38 метр гүнд) 5 метрийн зузаан интервалд 10.9 г/т AuEq (7.2 г/т Au, 29.8 г/т Ag, 2.64% Pb, 3.62% Zn) агуулсан 5.3 г/т AuEq (3.6 г/т Au, 14.4 г/т Ag, 1.15% Pb, 1.76% Zn) бүхий 12 метрийн зузаан интервал багтаж байна. 2015 оны 3-р улиралд хийсэн суваг малталтын ажил нь ордын хүдэржсэн бүсийг тодорхой хэмжээгээр тэлж өгсөн. Суваг ANT-41 нь Хойд Холбоон одоогийн нөөцийн хилээс зүүн зүгт ойролцоогоор 200 метр зайд байх ба 4.1 г/т AuEq (3.5 г/т Au, 5.0 г/т Ag, 0.70% Pb, 3.26% Zn) бүхий 8 метрийн зузаан интервал агуулсан 2.5 г/т AuEq (1.9 г/т Au, 4.3 г/т Ag, 0.78% Pb, 0.35% Zn) бүхий 28.5 метр интервалыг огтолсон.

2016 оны 4-р улирал – Хойд Холбооны өрөмдлөгийн ажлын хураангуй

2016 оны 4-р улирлын сүүлээр хийсэн өрөмдлөгийн судалгаагаар Хойд Холбоон хүдэржилтийн системийн боломжит хэмжээг тодорхой хэмжээгээр тэлж өгсөн. Талбай тэлэлтийн TND-97 цооног нь Компанийн 2015 оны 1-р улиралд тооцоологдсон ашигт малтмалын нөөцийн хилээс зүүн зүгт 155 метр зайд байх ба 34 метр гүнд 1.57 г/т AuEq (1.08 г/т Au, 5 г/т Ag ба 0.81% Pb-Zn) бүхий 22 метрийн зузаан интервалыг огтолсон. Энэ цооног нь өмнө нь 2.5 г/т AuEq (1.88 г/т Au, 4.3 г/т Ag ба 1.13% нэгдсэл Pb-Zn) бүхий 28.5 метр зузаан интервал илэрч байсан ANT-41 сувгийн доогуур өрөмдөгдсөн. Хойд Холбоон суналын нийт урт нь одоогоор 600 метр байгаа бөгөөд зүүн хойд, зүүн, өмнө зүгт болон гүндээ нээлттэй байгаа.

2017 оны 3-р улирал – Хойд Холбооны өрөмдлөгийн ажил

400 метр зайд талбайн зүүн тэлэлт дагуу 3 цооног (TND-119 – TND-121) өрөмдсөн ба 1 шинэ цооног (TND-122)-ийг Хойд Холбоо бүсээс зүүн урд зүгт 200 метр зайд тавьсан нь өндөр агуулга бүхий полиметаллын судлуудыг огтолсон (доор байх хүснэгтийг харна уу). Эдгээр зүүн тэлэлтийн цооногууд нь Хойд Холбоон хүдэржилтийн бүсийг зүүн зүгт ихээр тэлсэн ба хүдэржилт нь зүүн зүгт нээлттэй гэдгийг харуулж өгсөн.

Хойд Холбооны өрөмдлөгийн ажлын онцлох үр дүнгүүд

Цооног	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) (1)	Алт (г/т)	Мөнгө (г/т)	Хар тугалга (%)	Цайр (%)	Алтны дүйцэх нэгж (г/т)(2)
TND-119	38.4	42	3.6	0.06	5.3	0.44	0.78	0.76
TND-120	36.9	42	5.1	1.08	29.4	1.05	2.25	3.22
үүнд	39	40	1	2.43	55	1.70	3.10	5.72
TND-121	89.5	104	14.5	0.93	6.8	0.47	0.42	1.49
TND-122	105	132	27	0.14	3.0	0.19	0.53	0.56
үүнд	128	129	1	1.36	23.0	2.60	6.98	6.63

(1) (2) Дээрх хүснэгтүүдийн тайлбар хэсгийг үз.

Өрөмдлөгийн ажлын хураангуй – Бүс нутгийн хайгуулын боломжит талбай

Нарийвчилсан гадаргуун зураглал, чулуун дээж болон хөрсний геохимийн шинжилгээг геофизикийн цахилгаан болон соронзон хайгуултай хослуулснаар 18 боломжит талбайг Алтан Нарын 5.6 км урт хүдрийн бүсэд илрүүлсэн. Нээлтийн бүс болон Хойд Холбоогоос 57 бусад 16 талбайд харьцангуйгаар хайгуулын өрөмдлөг хийгдээгүй. Компани нь эрлийн өрөмдлөгийн ажил (2011-2012, 2016 оны 4-р улирал, 2017 оны 3-р улирал), суваг малталтын ажил (2013, 2014 оны 3-р улирал) болон оновчлох

өрөмдлөгийн ажлыг (2014 оны 2 болон 4-р улирал, 2015 оны 3-р улирал, 2016 оны 4-р улирал мөн 2017 оны 3-р улирал) нэн тэргүүний зорилт бүхий хэд хэдэн талбайд хийсэн. Нэмэлт өрөмдлөгийн ажил хийснээр Алтан Нарын одоогоор мэдэгдэж байгаа хүдэржилтийг тодорхой хэмжээгээр тэлэх боломжтой.

2017 оны 3 ба 4-р улирал –Магги талбайн эрлийн өрөмдлөг

Магги талбай нь Нээлтийн бүсээс хойд зүгт 800 м, Хойд Холбоо ордоос зүүн урагш 600 метр зайд байрлана. Урьд нь соронзон сарнилын гажилыг зүүн урагш 100 метр зайд байх цооногоор (TND-64) өрөмдөн шалгаж байсан. 2013 онд энэ талбайг олж нээснээс хойш энэ талбайд 3 цооног өрөмдөж 1 суваг малтсан. TND-123 цооног нь талбайн зүүн хойд үзүүрт байх 15.4 г/т хүртэлх алтны агуулгатай чулуун дээж бүхий филлик хувиралтай өргөн бүсийг шалгаж өрөмдсөн. TND-123 цооног нь 1 метрийн 23.8 г/т AuEq (22.3 г/т алт) агуулсан 5.3 г/т AuEq (4.8 г/т алт, 10.4 г/т мөнгө, 0.85% хар тугалга-цайр) бүхий 5 метр биетийг 31 метр гүнд огтолсон. TND-133 цооногийг хүдэржилтийг гүнрүү тэлэх боломжтой эсэхийг турших зорилгоор TND-123 цооногийн доогуур өрөмдсөн. 25 метр зузаан хүдэржилтгүй дайкийг эс тооцвол TND-133-р цооног нь дунджаар 0.7 г/т AuEq (0.4 г/т алт, 4.2 г/т мөнгө ба 0.46% хар тугалга-цайр) бүхий биет огтолсон ба үүний 4.8 г/т хүртэлх алтны агуулга бүхий 1 метр зузаан интервал байсан. Магги талбайд тавьсан эхний цооног (TND-64) нь 28 метрийн гүнд 22 метрийн 1.1 г/т алт огтолсон. Эдгээр 3 цооногтой хамгийн ойр цооног нь Хойд холбооноос баруун тийш 450 метрийн зайд оршдог. Магги талбайд цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулж байна.

2017 оны 3-р улирал – Жанкшин талбайн эрлийн өрөмдлөг

Жанкшин талбай нь Нээлтийн бүсээс зүүн зүгт 600 метр зайд байрлах ба 11.2 г/т хүртэлх алтны агуулгатай чулуун дээжнүүд, цахилгаан хайгуулын гажил болон түүнийг хучсан 350 х 450 метр талбайн хөрсний геохимийн аномальтайгаараа онцлог талбай юм. TND-127-р цооногт хүчтэй цахиуржсан галт уулын брекчийг зүссэн, халькопиритээр хүдэржсэн ижил чиглэл бүхий кварцын штокверк судлууд огтлогдсон ба 0.3% зэс, 0.14 г/т алт ба 7.5 г/т мөнгөний агуулга бүхий 12 метр зузаан интервал 150 метр гүнээс илэрсэн. Мөн энэ талбай дахь хэд хэдэн сонирхолтой хэсгийг одоогийн байдлаар өрөмдөж шалгаагүй байгаа. Зэсийн хүдэржилт нь дурдсан хэсэг болон залгаа талбай болох Соутгэйт (TND-48: 1 метр интервалд 4.4% хүртэлх зэс)-д өндөр байгаа нь “Алтан Нар”-ын энэ хэсэг нь хүдэржилтийн өндөр температурын хэсэг байх боломжтойг харуулж байна. Энэ шинэ бүс нь компанийн ирээдүйд хийх өрөмдлөгийн ажлын зорилтуудын нэг юм.

Геологи

Алтан Нар хэтийн төлөвт талбай нь хожуу Палеозойн (Девон-Карбоны) үеийн андезит галт уулын чулуулаг, галт уулаас шидэгдсэн туфт чулуулагт агуулагдах карбонат чулуулгийн эрдэс бүхий олон шатлалт эпитеpmаль алт-мөнгө-хар тугалга-цайрын хүдэржилт агуулдаг. Хүдэржилт нь сэрвэн кварц, хальцедоны судлууд, кварцын брекчүүд, сульфидийн брекчүүд болон кварцжсан брекчүүдийн бүс, мөн агуулагч трахит-андезит, андезит, андезит туфын чулуулгийн өргөн тархсан пропилитийн (эпидот-хлорит-монтморрилонит/иллит) хувирал, калийн хувирсан бүс, цагаан гялтгануурын хувирлын бүст (кварц-иллит±пирит) тархсан байдаг.

2018 оны нөөцийн тайлан

Корпораци нь 2015 оны 3 дугаар сард Алтан Нар төслийн нөөцийн тайланг, түүний шинэчилсэн дүнг 2018 оны 5-р сарын 10-нд танилцуулсан. АрПиЭмГлобал (RPMGlobal) компани нь Эрдэнэ Ресурсын өгсөн мэдээлэлд тулгуурлаж, боломжтой тохиолдолд баталгаажуулах замаар шинэчилсэн нөөцийн тайланг хийж гүйцэтгэсэн. Тус тайланд 2015 оны 1-р улирлаас 2017 оны 4-р улирал хүртэл хийсэн нийт 7,782 метрийн алмазан өрөмдлөгийн нэмэлт 51 цооногоос авсан үр дүнг багтаажээ. Дээрх өрөмдлөгийг Нээлтийн бүс, Хойд холбоо ордуудын тухайн үеийн нөөцийн зах хязгаарыг тэлэх, Алтан Нар төслийн 5.6 км чиглэл дэх үлдсэн 16 хайгуулын боломжит талбайн эрдэсжилтийг нэмж илрүүлж, өргөжүүлэн тэлэх зорилгоор хийсэн. Энэ ажлын дүнд нээлтийн бүсийн талбайд өндөр агуулга бүхий төв бүс байгааг олж илрүүлсэн бөгөөд хайгуулын боломжит нэмэлт талбай дахь нэмэлт нөөцийг тогтоосон. Ерөнхийдөө Нээлтийн бүсэд хийсэн өрөмдлөг нь шинэчилсэн нөөцийн хэмжээ зэрэгт ихээхэн нөлөөлсөн. Статистик дүн шинжилгээ, ашигт малтмалын нөөцийн тооцоог АрПиЭмГлобал компани хийж гүйцэтгэсэн болно.

Доорх Хүснэгт 1-15-д Алтан Нар төслийн Ашигт малтмалын нөөцийн тооцоог 2018 оны 5-р сарын 7-ны байдлаар харуулав. Ашигт малтмалын нөөцийг АрПиЭмГлобал компани NI 43-101-д заасан Канадын

Уул Уурхайн Хүрээлэнгийн стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн. АрПиЭмГлобал нь Алтан Нар төслийн ашигт малтмалын нөөцийг алтны тэнцэх нэгж (AuEq) буюу хэд хэдэн захын агуулгын утгатайгаар хийсэн хэдий ч АрПиЭмГлобал нь ашигт малтмалын нөөцийг ил уурхайн нөөцөд алтны захын агуулга 0.7 г/т AuEq, ил уурхайн амны үенцэрээс доош 1.4 г/т AuEq гэж тайлагнахыг зөвлөсөн. Хүснэгт 1-15 нь ил уурхайн амны үенцэрээс доошхи алтны захын агуулгын утга тогтмол 1.4 г/т AuEq байх үеийн ил уурхайн амны үенцэрээс дээшхи алтны захын хувьсагч агуулга бүхий металын агуулга, тоннын өөрчлөлтийг (0.4 г/т AuEq, 1.0 г/т AuEq, 1.4 г/т AuEq захын агуулгын утга) харуулж байна. Корпораци нь 2018 оны 5-р сарын 10-нд нөөцийн тайланг зарласнаас хойш 45 хоногийн дотор NI 43-101 Нөөцийн тооцоо, техникийн тайланг SEDAR-т тайлагнаана.

Хүснэгт 1-15 Алтан нар төсөл – Ашигт малтмалын нөөцийн тооцооны хураангуй,
2018 оны 5-р сарын 7

Захын агууламж AuEq	Нөөцийн ангилал	Тоо хэмжээ (Mt)	Зэрэг					Агуулагдах металл				
			Алт	Мөнгө	Цайр	Хар тугалг	Алтны дүйцэх нэгж	Алт	Мөнгө	Цайр	Хар тугалга	Алтны дүйцэх нэгж
г/т			г/т	г/т	%	%	г/т	Koz	Koz	Kt	Kt	Koz
0.4	Бодит	5.6	1.8	13.5	0.6	0.5	2.6	323	2,412	33.2	29.9	464
0.4	Боломжит	3.7	1.6	7.5	0.7	0.6	2.3	189	901	24.5	22.8	283
0.7	Бодит	5.0	2.0	14.8	0.6	0.6	2.8	318	2,350	31.6	29.0	453
0.7	Боломжит	3.4	1.7	7.9	0.7	0.7	2.5	186	866	23.7	22.3	277
1.0	Бодит	4.2	2.3	16.6	0.7	0.7	3.2	306	2,212	28.6	27.4	431
1.0	Боломжит	3.2	1.8	8.2	0.7	0.7	2.7	182	837	22.8	21.5	270
1.4	Бодит	3.3	2.7	18.9	0.8	0.8	3.8	285	2,002	24.9	25.2	398
1.4	Боломжит	2.9	1.9	8.6	0.8	0.7	2.8	176	795	21.5	20.4	259


Тайлбар:

1. Ашигт малтмалын нөөц нь байр зүйн зураглалаар хязгаарлагдах ба ил уурхайгаас дээшхи алтны захын агуулгын утга 0.7 г/т AuEq, амны үенцэрээс доошхи алтны захын агуулгын утга 1.4 г/т байхаар хязгаарлагдана.
2. Ашигт малтмалын нөөцийн тооцооны тодотгол нь Австралийн Газарзүйн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн, RPM-ын бүтэн цагийн ажилтан ноён Жерми Кларкийн удирдлага доор хийгдсэн. Ноён Кларк нь энэ төрлийн хүдэржилт болон ордын хангалттай туршлагатай ба Канадын уул уурхайн хүрээлэнгийн стандартад заасан мэргэжсэн мэргэжилтний шаардлагыг хангасан.
3. Дээр байгаа нөөцийн тооцоо нь 2018 оны 05-р сарын 7-ны тайланд орсон тооцоогоор байгаа ба ашигт малтмалын нөөцийн тооцоо нь нарийн тооцоолол биш бөгөөд талбайн хязгаарлагдмал мэдээлэл дээр үндэслэн хийгдсэн тайлал, хэлбэр болон илэрлийн үргэлжлэл мөн түүнчлэн өрмийн дээжийн үр дүнгүүдийн бэлэн байдлаас хамаардаг. Дээрх хүснэгтэнд байх нийлбэр дүн нь харьцангуй тодорхой бус тооцоог тоймлон харуулсан болно. ийнхүү тоймлосон нь зарим нэг тооцооллын ялгаа гаргаж болно.
4. Ашигт малтмалын нөөцийн зэргүүдийг Канадын уул уурхайн хүрээлэнгийн стандартын дагуу тайлагнаа.
5. Ашигт малтмалын нөөцийг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнаа.
6. Тайлагнасан ашигт малтмалын нөөцийн тооцоонд хорогдуулалт буюу метал алдалтын хүчин зүйлсийг тооцоогүй болно.
7. Уурхайн үйл ажиллагаанаас яваандаа бий болж болзошгүй алдагдлыг нөхөх нөхвөр хийгээгүй болно.
8. Алтны дүйцэх нэгж ("AuEq")-ийн тооцоололд металын үнийг 1 унци алт US \$1,310 ам.доллар, нэг унци мөнгө US \$18 ам.доллар, нэг тонн хар тугалга US \$2,400 ам.доллар, нэг тонн цайр US \$3,100 ам.доллар, харин боловсруулалтын өртөө дараах байдалтай байна гэж тооцов.

Нөөцийн шинэчилсэн тооцоогоор Алтан Нар төслийн 2015 оны 3-р сарын нөөцийн анхны тооцоололтой харьцуулахад алтны дүйцэх нэгжээр ("AuEq") илэрхийлэгдэх бодит нөөцөд 208%-ийн өсөлт, боломжит нөөцөд 172%-ийн өсөлт тодорхойлогдсон. Түүнчлэн бодит нөөц дунджаар 2.8 г/т AuEq буюу 452,900 унци ("oz") AuEq болж, боломжит нөөц дунджаар 2.5 г/т AuEq буюу 277,100 унци AuEq болж өссөн буюу нийт бодит нөөц 5.0 сая тонн ("Mt"), боломжит нөөц 3.4 Mt болов. Бодит нөөцөд 317,700 унци алт (дундаж нь 2.0 г/т алт), 31,600 тонн ("t") цайр, 29,000 тн хар тугалга, 2.35 сая унци мөнгө, харин боломжит нөөцөд 185,700 унци алт (дундаж нь 1.7 г/т алт), 23,700 тн цайр, 22,300 тн хар тугалга, 865,900 унци мөнгө агуулагдаж байна. Бодит нөөцийн AuEq утга 12%-аар, боломжит нөөц 19%-аар өссөн бол бодит нөөцийн алтны агуулга 18%-аар, боломжит нөөц 13%-аар өссөн байна.

Ашигт малтмалын нөөцийн ойролцоогоор 90% нь гадаргаас 150 метрт, страйк болон гүндээ нээлттэй оршино. Түүнчлэн Алтан Нарын 5.6 км чиглэлийн дагуу өрөмдлөг хийгдээгүй болон хайгуулын өрөмдлөг хийгдсэн хэд хэдэн цэг нь алт-полиметаллын нэмэлт нөөц агуулж байх магадлалтай юм.

Төв Алтан нар – Хайгуулын өндөр дүн бүхий 2018 оны 5-р сарын нөөцийн тооцоо



Алтны захын агуулгыг тооцохдоо АрПиЭмГлобал компанийн ашигласан параметруудийн талаар цаашид дэлгэрүүлэн үзэх бол корпорацийн 2018 оны 5-р сарын 10-нд гаргасан хэвлэлийн мэдээг харна уу.

Геофизикийн судалгаа

Алтан Нар төслийн талбайд 2014 онд газрын геофизикийн судалгааны агаарын зургийн хамрах хүрээг өргөжүүлж, Хойд нум (North Bow), Өмнөд нум (South Bow), Риверсайд (Riverside), Хойд холбоо (Union North), Өмнөд холбоо (Union South), Магги (Maggie) хайгуулын талбайг хамарсан 100 метрийн зайтай шугамын дагуу 20 километрийн хос туйлт өдөөгдөх туйлшралын ("IP") судалгааг хийж гүйцэтгэсэн. Өнөөгийн байдлаар туйлшралын өндөр аномаль нь алтны хүдэржилтийн бүсийг амжилттай тогтоох чухал чиглүүлэгч болсон. Өмнөх өдөөгдөх туйлшралын градиент матрицийн судалгаагаар 190 хүртэлх метрийн өргөнтэй туйлшралын хэд хэдэн өндөр аномалийг тодорхойлсон ба тэдгээрийг сульфидийн хүдэржилтийн өргөн бүсийг илэрхийлж байна хэмээн тайлсан. Эдгээр өдөөгдөх туйлшралын (IP) аномалиудын ихэнх нь гадаргын геохимийн аномалиудтай (чулуулаг болон хөрсний) хамааралтай байв. Өдөөгдөх туйлшралын (IP) аномалиудын хэлбэр бүтэц нь сансрын зураг дээрх ил дүрсний геометртэй хоршин хүдэржилт структурын тэлэлтийн бүстэй хамааралтай байж болохыг харуулж байна. Өдөөгдөх туйлшралын (IP) судалгааны илрүүлэлтийн ойролцоогоор 150 метрийн хязгаараас доош үргэлжлэх, гадаргад ойр байдлаас гүнрүүгээ тэлсэн, олон тооны, эрчимтэй, туйлшралын өндөр аномалиуд байгааг 2014 оны 2-р улиралд хийсэн судалгаагаар илрүүлсэн. Ялангуяа Хойд нум (North Bow), Өмнөд нум (South Bow), Хойд холбоо (Union North), Өмнөд холбоо (Union South) зэрэг хайгуулын талбайн доорх аномалиуд нэн хүчтэй илэрч байна. Геофизикийн хайгуулын боломжит эдгээр талбайн дийлэнхийг өрөмдлөгөөр баталгаажуулах шаардлагатай байгаа юм.

Нээлтийн бүсийн 500x500 метр талбайд 2016 оны 4-р улиралд 10 метрийн зайтай шугам ашиглан хийсэн өндөр нягтаршилтай газрын соронзон чиглэлийн судалгааг хийсэн. Судалгаагаар тус судалгааны талбай дах хүдэржсэн гол бүсүүд болон агуулагч цагаан гялтгануурын хувирлын бүсийг амжилттай чиглүүлэн тогтоосон. Өндөр нягтаршилтай газрын соронзон чиглэлийн судалгааг нийт 1,000 судалгааны тууш километрийн дагуу 10 метрийн зайтай шугамаар 2017 оны 2-р улиралд Алтан нар төслийн талбайг бүхэлд нь хамруулан хийсэн.

2017 оны 2-р улиралд 150 метрийн туйлшралын зайтай хос туйлт өдөөгдөх туйлшралын (IP) 6 шугамт судалгааг хийсэн. Судалгааны шугамууд нь 135 градуст чиглэсэн, Нээлтийн бүсэд төвлөрсөн, нийт 2,850 метрийн урттай байв. Сульфидийн хүдэржилтийг илэрхийлэх туйлшралын өндөр аномаль

байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийсэн.

Дээр дурдсан 2017 оны 2-3-р улирлын болон 4-р улиралд Нээлтийн бүс, Хойд холбооны бүсээс гаднах 16 талбайн заримд нь хийх хайгуулын боломжит талбайг тодорхойлох өрөмдлөгийн ажлыг чиглүүлэхэд 2-р улиралд хийсэн соронзон болон өдөөгдөх туйлшралын (IP) судалгааг ашигласан.

Металлургийн сорьцлолт

Компани нь 2015 оны 3-р улирлын турш Нээлтийн бүс болон Хойд Холбоо ордуудын өрмийн дээжүүдэд металлургийн судалгааг хийсэн бөгөөд судалгааны ажлыг Бритиш Колумбын Парксвиллийн Блү Көэст Ресерч ХХК ("BCR", "Blue Coast Research") хийж гүйцэтгэсэн ба Алтан Нарын металлургийн анхан шатны үнэлгээг хийхээр төлөвлөсөн. Үүнд цианидад уусгах, хөвүүлэх, хүндийн хүчний болон хүнд уусмалаар салгах аргууд багтсан.

Нээлтийн бүсийн дээжинд хийсэн металлургийн судалгаагаар шууд цианидад уусгах аргын металл авалт 88% (80% нь 75 микрон хүртэл нунтаглагдсан) байсан ба бутлуулаар чөлөөлөгдөх алттай ба сөрөг нөлөө бүхий найрлагагүй болохыг тогтоосон. Судалгаа нь стандарт 48 цагийн лонх эргүүлэх аргаар 40% хатуу, 1.0 г/л NaCN-н найрлагатай цианидын уусмалд хийгдсэн ба хүчил шүлтийн хэмжээ (pH) нь 10.5-11 хооронд тохируулагдсан. Мөн ууссан хүчилтөрөгчийн хэмжээ нь 5 мг/л-с их байхаар тохируулагдсан. Цианид (0.96 кг/т) болон шохой (1.51 кг/т) аль алины хэрэглээ дунд зэрэг байсан ба харьцангуй бага урвалын зардалтайг харуулж байна.

Хөвүүлэх аргын үр дүн нь алт-хар тугалга-мөнгөний баяжмалыг (229 г/т алт, 62% хар тугалга болон 1029 г/т мөнгө) уламжлалт хар тугалга – цайрыг ялган хөвүүлэх аргыг ашиглан боломжийн металлын авалттай (алт 75%, хар тугалга 74% болон мөнгө 64%) боловсруулж болохыг харуулсан.

Цианидад уусгах болон илүү боловсронгуйгаар хөвүүлэх аргуудыг Хойд Холбоон нэг нэг дээжинд буюу Нээлтийн бүсийн судалгаатай төстэй нөхцөлд хийн гүйцэтгэсэн. Цианадад уусгах аргын металл авалт 68% байсан. Харин хөвүүлэх аргад Хойд Холбоон дээжин дэх алт нь сульфидын баяжмалд 24% металл авалт ба хар тугалгын баяжмалд 45% металл авалттай байсан. Хойд Холбоон дээжинд оновчтой болгох ажил хийгдээгүй.

BCR нь урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл ("ТЭЗҮ"), техник эдийн засгийн үндэслэл хүртэл концепт судалгааны бүдүүвчийг хөгжүүлдэг бөгөөд гарааны бизнес, боловсруулах үйлдвэрийн оновчлолын зөвлөгөө өгдөг. Тэдний мэргэжилтнүүд нь полиметалл болон үнэт металлын баяжмалын олон улсын түвшинд өргөн туршлагатай.

Дүгнэлт, зөвлөмж

2015 оны 1-р улирлын нөөцийн анхны тооцоог гаргах зорилгоор хийсэн өрөмдлөгийн ажлуудын дүнд 2018 оны 5-р сард шинэчлэгдэн гарсан нөөцийн тооцоо нэлээд нэмэгдсэн дүнтэй байна. Түүнчлэн эдгээр өрөмдлөгийн ажлууд нь Алтан Нар болон одоогийн нөөцийн хил хязгаарын гаднах мэдэгдэж буй алт-полиметаллын хүдэржилтийн талбайн одоогийн нөөцийн тооцоог өргөжүүлэх боломжтой гэж үзэх Корпорацийн итгэлийг нэмэгдүүлсэн юм.

2017 онд хийгдсэн өрөмдлөгийн ажлууд нь томоохон тогтоцын тэлэлтийн бүсэд байрлах Нээлтийн бүсийн төв хэсгийн өндөр агуулга бүхий шинэ бүсийн судлыг цааш үргэлжлүүлэх, эсвэл металлээр баяжсан өргөн бүс байх боломж бүхий шилжилт болон гол структуруудын огтлолцол дээр байрласан болохыг баталгаажуулахаар төвлөрч ажилласан. 2017 онд Алтан Нар төсөлд хийгдсэн өндөр нарийвчлалтай соронзон хайгуулын үр дүн нь Нээлтийн бүсэд ажиглагддаг хөндлөн зүссэн структуртай ижил төстэй структурыг 5.6 км урт хүдэржсэн корридор бусад 17 талбайд илрүүлэхэд ашиглаж байна. Алтан Нар төслийн хүрээнд 2017 оны 3-р улиралд структурын судалгааны ажил хийсэн ба үр дүнг хайгуулын өрөмдлөгийн хэтийн төлөвлөлтөнд ашиглана.

Нээлтийн бүсийн төвд шинэ нээлт илрүүлсэн үргэлжилсэн өрөмдлөг нь нэмэлт өрөмдлөг хийх шаардлагатайг илтгэж байна. Алтан Нар төсөлд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай техникийн янз бүрийн судалгаа, тухайлбал гидрогеологи, археологи, палентеологи, байгаль орчны суурь судалгааг хийхээр төлөвлөж байна.

Алтан Нарын мэдээллийн баталгаажуулалт, хайгуулын ажлын мэдээллийг Корпорацийн SEDAR-т байршуулсан дараах баримт бичгээс үзэх боломжтой.

Үүнд:

- Монгол Улсын баруун өмнөд хэсэг, Баянхонгор аймаг, Алтан нар алтны төсөл, Үндэсний стандарт 43-101 Техникийн тайлан”, Техникийн тайлан, 2015 оны 3 дугаар сар.
- 2015 оны 9-р сарын 16-ны мэдээ, “Эрдэнэ Ресурсын Алтан Нар төсөлд хийсэн металлургийн шинжилгээгээр металл авалт 88% байна; РунгеПинкокМинаркогоор хараат бус стратегийн опционы дүн шинжилгээ хийлгэнэ”
- 2015 оны 10-р сарын 15-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс Алтан Нар Нээлтийн бүсэд 9 метрийн 9.2 г/т алтны дүйцэх нэгж бүхий өндөр агуулгатай алт-полиметаллын огтлолцол илрүүлэв”
- 2015 оны 11-р сарын 16-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс төслийн хяналт судалгаа, санхүүгийн улирлын үр дүнгээ тайлагнав”
- 2016 оны 12-р сарын 19-ний мэдээ, “Эрдэнэ Ресурсын Алтан Нар төсөлд 9.3 г/т алтны агуулга бүхий 110 метрийн зузаан интервал огтлогдов”
- 2017 оны 10-р сарын 12-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс Алтан Нар төсөлд 10.3 г/т алтны агуулга бүхий 20 метрийн зузаан интервал огтолж, Баян Хөндий болон Алтан Нар төслийн өрөмдлөгийг 33,000 метрээр тэлэв”
- 2018 оны 1-р сарын 24-ний мэдээ, “Эрдэнэ Ресурс Бүс нутгийн хайгуулын ажлын талаар мэдээлэв; Баян Хөндийгөөс 3.4 км зайд, Алтан Сум талбайд алтны өндөр агуулга буюу 70 г/т алтны агуулга бүхий 2 гаруй метрийн зузаан интервал огтлогдов”
- 2018 оны 5-р сарын 10-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс Алтан Нар алт-полиметаллын төслийн нөөцийг нэмэгдүүлэв”

Алтан Сум алтны төсөл (Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд)

Корпораци нь 2017 оны туршид Баян Хөндий төслийн хойд хэсэгт томоохон хайгуулын ажил хийж гүйцэтгэн, цахиурлаг бөгөөд хөндий кварц, хүчтэй шаварлаг болон нэлээд идэвхтэй шаварлаг хувирлын олон тооны бүс, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн төв хэсгийг бүрхсэн 3х6 километрийн талбайд аномаль алт илрүүлэн тогтоосон. Баян Хөндий төслийн талбайгаас хойш 3.4 болон 3.2 километрийн зайтай орших Алтан Сум алт-мөнгөний төсөл, Хойд Хөндий алтны хэтийн төлөвт талбайд голлон анхаарч ажилласан.

Корпораци 2013 онд Алтан Сум талбайд хайгуул хийж, эпитеpmаль кварц судлууд болон брекчид өндөр агуулга байгааг баталгаажуулсан ба гар дээжээр 57 г/т хүртэлх алт, сувгийн малталтаар 31.4 г/т алтны агуулга бүхий 1 метр болон 4.5 г/т алтны агуулга бүхий 6 метрийн зузаан интервал бүхий хүдэржилтийн илүү өргөн бүс байх магадлалтайг тогтоосон. Корпораци 2017 оны 2-р улиралд Алтан Сум талбайд зүүн хойш чиглэлтэй сунасан хагарлын зэрэгцээ 0.5х1 километр талбайд олон тооны өндөр агуулгатай эпитеpmаль кварц судлууд агуулагдаж байгааг тодорхойлсрн.

Корпораци 2017 оны 4-р улиралд Алтан Сум талбайд хийсэн хайгуулын ажлын хүрээнд нэг цооногоос зүүн хойш чиглэсэн гол структураас өмнө зүгт 200 гаруй метр сунаж тогтсон хөрсөн дэх өндөр аномаль бүхий алтны структур огтолсон. Үүний дараагаар 2017 оны 3-р улиралд хөрсний аномальд хийсэн гадаргын дээжлэлт, геологийн зураглалаар зүүнээс баруун тийш чиглэсэн структурын дагуу 27 г/т алт агуулсан гадаргын кварц бул чулуу илрүүлсэн. Энэхүү шинэ нээлтийн гүнийг AAD-11 гэх нэг цооногоор шалгаж үзэхэд 11 метрийн босоо гүнд 1 метрийн 39 г/т алт, 8 г/т мөнгө агуулсан гүн бус алт агуулагч эпитеpmаль судлууд бүхий олон тооны, аномаль алтны бүсүүд цооногийн 100 метрийн уртад тархсан (45 градусын өнцөг) байдалтай огтлогдсон. Аномаль алт (0.1 - 0.3 г/т) нь кварц судлуудаар огтлогдсон кварц-серицитийн хувирмал Девоны андезитийн 14 метр өргөн бүсийг тойрон огтлогдсон байна.

2017 оны 4-р улирлын өрөмдлөгийн ажлаас өмнө зүүнээс баруун тийш чиглэлтэй энэхүү структурт гүйцэтгэсэн цорын ганц цооног нь AAD-11 цооногоос зүүн тийш 300 метрийн зайд байрлах AAD-03 цооног байв. AAD-03 цооног нь 50 метрийн босоо гүнд 23.5 г/т алтны агуулга бүхий 2 метрийн зузаан интервал огтолсон. AAD-12 нь тус огтолцлын гүнийг тодорхойлох зорилгоор өрөмдсөн 150 метрийн гүн цооног байсан бөгөөд энэ нь эхний огтлолоор 70.1 г/т алтны агуулга бүхий 2 метрийн зузаан интервал, хоёр дахь огтлолоор гадаргаас 100 метрийн зайд 1.3 г/т алтны агуулга бүхий 2 метрийн зузаан интервал огтолсон.

Хөндий хойд талбай

Хөндий хойд талбай нь Баян Хөндийгөөс хойш 3.2 км, Алтан Сум талбайгаас зүүн тийш 265 км зайтай оршдог. Баян Хөндий болон Алтан Сумаар дайран өнгөрдөг зүүн хойш чиглэлтэй хугарал нь

хөндий бүсэд байх бүс нутгийн зүйн хойш чиглэлтэй өргөн хугаралын томоохон сүлжээний нэг хэсэг юм. Баян Хөндийг хэрсэн энэхүү структур нь зүүн хойноос судлагдаагүй байгаа Хөндий хойд талбай хүртэл үргэлжлэнэ. Энд кварцын штокверк судлууд, гематит брекчийн хэлтэрхий бүхий хальцедон кварцын судлууд 1 км гаруй үргэлжлэнэ. 5 чулуулгаас авсан дээжээр 0.5 г/т-с их, 22.7 г/т хүртэлх алтны агуулга илэрсэн.

2017 оны 3-р улирлын бүс нутгийн судалгаа

Хөндий тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь хамарсан геологийн нарийвчилсан зураглал хийх, хэтийн төлөв тодорхойлох, чөмгөн дээж авах ажлыг 2017 оны 3-р улиралд хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн мөн хугацаанд Баян Хөндий төслийн хойд хэсгээс тусгай зөвшөөрөлт талбайн хойд хязгаар хүртэлх (ойролцоогоор 10 км) талбайд хөрсний геохимийн судалгааг хийж, 100м болон 200 метрийн тороор өрөмдөн дээж авсан. 3-р улиралд Баян Хөндий төслөөс Алтан Сум талбайн хойд хэсэг хүртэлх 22 км² талбайд геофизикийн судалгаа хийсэн. Энэ хүрээнд 25 метрийн тууш зайтай 900 тууш км соронзон орны судалгаа, 150 метрийн туйлшралын зайтай 2 туйлт өдөөгдсөн туйлшралын судалгаа хийгдсэн. Эдгээр бүс нутгийн судалгааны дүнг 2018 оны хэтийн төлөвт өрөмдлөгийн талбайг тодорхойлоход ашиглаж байна.


Алтан Сумын мэдээллийн баталгаажуулалт, хайгуулын ажлын мэдээллийг Корпорацийн SEDAR-т байршуулсан дараах баримт бичгээс үзэх боломжтой. Үүнд:

- 2016 оны 12-р сарын 19-ний мэдээ, “Эрдэнэ Ресурс Алтан Нар талбайд 9.3 г/т алтны агуулга бүхий 110 метр зузаан интервал огтоллоо”
- 2018 оны 1-р сарын 24-ний мэдээ, “Эрдэнэ Ресурс Бүс нутгийн хайгуулын ажлын талаар мэдээлэв; Баян Хөндийгөөс 3.4 км зайд, Алтан Сум талбайд алтны өндөр агуулга буюу 70 г/т алтны агуулга бүхий 2 метрийн зузаан интервал

Улаан зэс-алтны порфирийн төсөл

Корпораци нь 2017 оны 8-р сарын 30-нд Баян Хөндий алтны төслийн чанх баруунтай орших Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн 51%-ийг 100% хүртэл худалдан авах нөхцөлтэйгээр худалдан авсан (доорх зургийг харна уу). Улаан талбай нь 1,780 га талбайтай бөгөөд энд том хэмжээтэй буюу 3 км-ийн диаметр бүхий гүндээ эзсийн порфир болон эпитермаль алтны системтэй холбоотой байж болохуйц хүчтэй хувирсан бүс оршдог. Энэ хайгуулын тусгай зөвшөөрөл нь хайгуулын тусгай зөвшөөрлийн 12 жилийн 3 дахь жилд хайгуул нь хийгдэж байгаа. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг 12 жилийн хугацаа дуусахаас өмнө хэдийд ч ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой байдаг. Улаан талбайд урьд нь өрөмдлөг эсвэл суваг малталтын ажил хийж байгаагүй хэдий ч гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн бөөгнөрөл бүхий гажил байгааг тогтоосон. Саяхан хийж гүйцэтгэсэн геофизикийн судалгаагаар хэд хэдэн төлөв бүхий талбайг илрүүлсэн. Гэрээний нөхцөл ёсоор Эрдэнэ Ресурс нь тусгай зөвшөөрлийг эзэмшигч Лидер Эксплорэйшн ХХК-ийн 51%-ийг 3.Эрдэнэчулуун, 3.Эрдэнэхуяг нараас \$750,000 ам.доллараар худалдан авсан. Цаашид 3 жилийн турш \$600,000 ам.долларын хайгуулын ажлыг энэхүү талбайд хийснээр үлдсэн 49%-ийг тухайн үеийн үнэлгээгээр 3.Эрдэнэчулуунаас худалдан авах эрх үүснэ. Эрдэнэ Ресурс энэхүү 3 жилийн опционы хугацааг жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар сунгах боломжтой.

Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцээ 3 км хүчтэй хувирлын бүсийг харуулсан Улаан талбайн зураг



2017 оны 3 болон 4-р улирлын эхээр Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь хамарсан хайгуулын ажилд нарийвчилсан геологийн зураглал, эрлийн ажил болон чулуун дээжлэлт, 100 метрийн тороор авсан 1,739 хөрсний дээж, 89 тууш км урттай хос туйл-хос туйлт цахилгаан хайгуул зэрэг багтаж байна. Хөндий тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь хамарсан геологийн нарийвчилсан зураглал хийх, хэтийн төлөв тодорхойлох, чөмгөн дээж авах ажлыг 2017 оны 3-р улиралд хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн мөн хугацаанд Баян Хөндий төслийн хойд хэсгээс тусгай зөвшөөрөлт талбайн хойд хязгаар хүртэлх (ойролцоогоор 10 км) талбайд хөрсний геохимийн судалгааг хийж, 100м болон 200 метрийн тороор өрөмдөн дээж авсан. Эдгээр бүс нутгийн судалгааны дүнг 2018 оны 2-р улирлын тороор хөрснөөс нарийвчилсан дээж авах, хос туйлт өдөөгдөх туйлшралын судалгаа, тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд таталцлын хүчний судалгаа, хэтийн төлөв өндөртэй талбайнуудад анхны суваг таталтыг хийх зэрэг хайгуулын ажилд ашиглана.

Энэ ажлын үр дүн нь 2018 онд хийх өрөмдлөгийн ажлыг чиглүүлэх юм.

Улаан төслийн мэдээллийн баталгаажуулалт, хайгуулын ажлын мэдээллийг Корпорацийн SEDAR-т байршуулсан дараах баримт бичгээс үзэх боломжтой. Үүнд:

- 2017 оны 8-р сарын 22-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс Баян Хөндий алтны төслийн зэргэлдээх хайгуулын тусгай зөвшөөрлийг 100% худалдан авах эрхийн дийлэнх хэсгийг худалдан авна, Халифакс, Нова Скотиа”

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. | Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ

- 2017 оны 8-р сарын 30-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс Баян Хөндий алтны бүсэд эзэмших газраа тэллээ; Улаан төслийг худалдан авах хэлцэл хийв”
- 2018 оны 1-р сарын 24-ний мэдээ, “Эрдэнэ Ресурс Бүс нутгийн хайгуулын ажлын талаар мэдээлэв; Баян Хөндийгөөс 3.4 км зайд, Алтан Сум талбайд алтны өндөр агуулга буюу 70 г/т алтны агуулга бүхий 2 метрийн зузаан интервал огтлогдов”

Зуун Мод молибденийн төсөл (Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд байрлана)

Зуун Мод молибденийн төсөл нь молибден-зэс порфирын орд бөгөөд Монголын баруун өмнөд хэсэгт оршино. Улаанбаатар хотоос баруун урд зүгт ойролцоогоор 950 км, Монгол-Хятадын хил дээрх Цэхийн галт тэрэгний боомтоос 215 км зайд байрладаг. Энэ өртөө нь Нарийн Сухайт болон Овоот Толгой нүүрсний уурхайгаас урд зүгт 50 км-т байрладаг. Төсөл нь нийт 6,041 га талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Энэ ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Компанийн охин компани болох Аниан Ресорсиз ХХК-ийн эзэмшилд байдаг ба ашиглалтын тусгай зөвшөөрөл нь эхний 30 жилийн хугацаанд явж байна. Энэ төслийг Галлант Минералс Лимитэд компаниас 2005 онд авсан бөгөөд худалдаж авах боломжтойгоор 1.5%-ийн нөөцийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн.

Корпораци нь 2011 оны 2-р улиралд Компани NI 43-101 кодын дагуу Зуун Модын нөөцийг тооцоолон олон нийтэд ил болгосон. Захын агуулгыг 0.04% молибден гэж тооцон, дунджаар 0.057% молибден болон 0.069% зэсийн агуулгатай 218 сая тоннын (“Мтн”) тогтоогдсон болон бодит нөөцтэй гэж тооцоолсон (0.056% молибден болон 0.064% зэсийн агуулгатай 40 Мтн тогтоогдсон нөөц болон 0.057% молибден болон 0.07% зэсийн агуулгатай 178 Мтн бодит нөөц). Энэ нь металл молибден агуулсан 273.5 сая фунт болон металл зэс агуулсан 330.7 сая фунттэй тэнцэнэ. Үүнээс гадна Зуун Модод дунджаар 0.052% молибден болон 0.065% зэсийн агуулгатай 168 сая тн таамаг нөөц байгаа ба энэ нь металл молибден агуулсан 191.8 сая фунт болон металл зэс агуулсан 240.5 сая фунттэй тэнцэнэ. Тайланд орсон Зуун Модын бүх молибден-зэсийн нөөц нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд багтана.

Молибденийн үнэ өсөх үед Зуун Модын молибден-зэсийн төслийг хөгжүүлэх боломж бүрдэнэ гэж Удирдлагын зүгээс итгэж байна. 2004 болон 2005 онуудад фунт тутам \$40 ам.доллар хүрч байсан молибденийн үнэ 2017 оны 12-р сарын 31-ний байдлаар фунт тутам нь 7.25\$ болон огцом унаж, зах зээл дээрх молибденийн эрэлт буурсан. Молибденийн зах зээлийн үнийн өсөлт нь Зуун Модын молибден-зэсийн ордыг хөдөлгөх чухал хүчин зүйл болно. Компани нь технологи болон/эсвэл хайгуултай холбоотой нэмэлт мэдээлэл гармагц төслийн эдийн засгийн оновчлолын үнэлгээг үргэлжлүүлэн хийнэ. Хөвийн Хар төсөлд зэсийн тодорхой хэмжээний нэмэлт хүдэржилт илрүүлснээр Зуун Мод молибденийн ордыг хөдөлгөх хөшүүрэг болох боломжтой.

Зуун Мод талбайн мэдээллийн баталгаажуулалт, хайгуулын ажлын мэдээллийг Корпорацийн SEDAR-т байршуулсан дараах баримт бичгээс үзэх боломжтой. Үүнд:

- Монгол Улсын баруун өмнөд хэсэг, Зуун Мод порфир молибден-зэсийн төсөл, Үндэсний стандарт 43-101 Техникийн тайлан”, 2011 оны 6 дугаар сар.

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл (Хөвийн хар тусгай зөвшөөрлийн талбайд байрлана)

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл нь Зуун Модын талбайд байх ба Зуун Мод молибден-зэсийн порфирийн ордоос (дээр дурдсан) баруун хойд зүгт 2.2 км байрладаг. Хөвийн Хард геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хоорондох зай нь хол байх өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилтай цэг шалгах өрөмдлөгийн ажлаар 308-342 метр гүнд 34 метрийн 1.3% зэс болон 9.24 г/т мөнгөтэй интервал огтолсон (цооног ZMD-121). Хөвийн Хард хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-иас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалууд (12-42 метр) огтлогдсон.

Өмнөх хайгуулын ажлаар зэс порфирийн төрлийн хүдэржилт Хөвийн Хар талбайд байгааг баталгаажуулсан.

Корпораци нь тусгай зөвшөөрлөө хадгалж үлдэхэд шаардлагатай ажлыг Зуун Мод молебден-зэсийн орд болон Хөвийн Хар зэс-мөнгөний төслүүдэд хийж гүйцэтгэх ба үүнд жил бүр төлөгддөг тусгай зөвшөөрлийн төлбөр, байгаль орчны дүгнэлт болон орон нутгийн хөгжлийн ажлууд багтаж байна.

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөлд 2018 онд хайгуулын ажил төсөвлөгдөөгүй болно.

Хөвийн Хар талбайн мэдээллийн баталгаажуулалт, хайгуулын ажлын мэдээллийг Корпорацийн SEDAR-т байршуулсан дараах баримт бичгээс үзэх боломжтой. Үүнд:

- 2015 оны 11-р сарын 16-ны мэдээ, “Эрдэнэ Ресурс төслийн хяналт судалгаа, санхүүгийн улирлын үр дүнг тайлагнав”

Гэрээгээр хүлээсэн үүрэг

Доорх хүснэгтэд 2018 оны 6-р сарын 30-ны байдлаарх Корпорацийн хүлээсэн гэрээний үүргийг хураангуйлав. Үүнд:

Гэрээгээр хүлээсэн үүрэг	Нийт	1 жилээс бага	1-3 жил	4-5 жил	5 жилээс дээш
Оффисийн түрээс	\$ 73,425	\$ 62,936	\$10,489	\$ -	\$ -
Дансны өглөг ба хуримтлагдсан өр төлбөр	507,973	507,973	-	-	-
	\$ 581,398	\$570,909	\$10,489	\$ -	\$ -

Галлант Минералс Лимитэд (Gallant Minerals Limited) нь Зуун Модын тусгай зөвшөөрөл борлуулалтын цэвэр ашгаас (БЦА) 1.5%-ийн БЦА төлбөр авах эрхтэй. Зуун Мод хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын ажлын төлөвлөгөө хийгдээгүй.

Сандсторм Гоулд Лтд. (Sandstorm Gold Ltd.) нь Цэнхэр номин, Хөндийн тусгай зөвшөөрөл борлуулалтын цэвэр ашгаас (БЦА) 2%-ийн БЦА төлбөр авах эрхтэй. БЦА төлбөрийг бууруулах боломжтой.

2017 онд Корпорацийн Цэнхэр Номин, Хөндийн тусгай зөвшөөрлийн талбайн нэг га-д хамгийн багадаа \$1.50 ам.долларын (тус бүр \$7,004 ам.доллар ба \$6,771 ам.доллар) хайгуулын зардал гаргах шаардлагатай болсон.

Корпораци нь 3 жилийн турш \$600,000 ам.долларын хайгуулын ажлыг Улаан талбайд хийснээр Лидер эксплорэйшн ХХК-ийн үлдсэн 49%-ийг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдан авах эрх үүснэ. Корпораци нь жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар энэхүү 3 жилийн опционы хугацааг сунгах боломжтой.

Балансын гадуурх зохицуулалт

Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар батлан даалтын гэрээ, өөр бусад байгууллагад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болзошгүй үүрэг, үүсмэл хэрэгсэл буюу Корпорацид санхүүжилт, хөрвөх чадвар, зах зээлийн болон зээлийн эрсдэл учруулж болзошгүй аливаа үүрэг гэх мэт балансын гадуурх аливаа зохицуулалт хийгээгүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол

Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дүнгийн тооцоолол

Үйл явдал, нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан тодорхой жилд үнэ цэн бууралтын гарз гарах буюу үнэ цэнэ бууралтын гарзын буцаах бичилт хийх шаардлага гарч болно.

Корпорацийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу санхүүгийн бус хөрөнгө буюу мөнгө бий болгох нэгжийг тайлант жил бүр үнэлж, үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг нягтална. Хэрэв ийм шинж тэмдэг байгаа бол нөхөгдөх дүнг албан ёсоор тооцоолж, нөхөгдөх дүнгээс хэтэрсэн дансны үнээр үнэ цэн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн буюу мөнгө бий болгох нэгжийн нөхөгдөх

дүнг хөрөнгийн борлуулалтын цэвэр үнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль ихээр бүртгэнэ. Гүүдвилийн зорилгоор жил бүр үнэ цэн бууралтыг шалгана.

Бодит үнэ цэнийг холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгө солилцож болох дүн гэж тодорхойлох ба ерөнхийдөө хэтийн төлөвт талбайг өргөжүүлэх, яваандаа данснаас хасах байдлаар хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаас үүсэхээр хүлээгдэж байгаа тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ юм. Ашиглалтын үнэ цэнэ гэдэг нь хөрөнгийг өнөөгийн хэлбэрээр нь тасралтгүй ашигласнаас болон ашиглахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж байгаа тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ юм. Өнөөгийн үнэ цэнийг тухайн хөрөнгөд агуулагдах эрсдэлүүдэд тохирох эрсдэлийн тохируулалттай татварын өмнөх хорогдуулагч ашиглан тодорхойлно.

Ирээдүйн мөнгөн урсгалын тооцоолол нь хүлээгдэж буй үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ (одоогийн болон түүхэн үнэ, үнийн чиг хандлага, холбогдох хүчин зүйлсийг харгалзана), нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээлтийн зардал, ирээдүйн капитал зардалд тулгуурлана. Хөрөнгийн нөхөгдөх дүнд нөлөө үзүүлж болзошгүй төсөөлөл нь нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгдөх боломжтой тул энэхүү бодлого нь эрсдэл болон тодорхой бус байдалд өртөж болзошгүй эдгээр тооцоолол, төсөөллийг хийхийг удирдлагаас шаарддаг. Энэ тохиолдолд хөрөнгийн дансны үнэ бүхэлдээ буюу хэсэгчлэн буурч болох ба үнэ цэнийн бууралтыг орлогын тайлангаас хасна.

Хувьцаанд суурилсан төлбөр

Ажилтнуудад олгосон өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөрийг олгосон өдрөөр бодит үнэ цэнээр (зах зээлд сурилаагүй баталгаажих нөхцөлийн нөлөөг тооцохгүй) бүртгэнэ. Бодит үнэ цэнийг Блэк Шолсийн үнэлгээний загварыг ашиглан тооцох ба ингэхдээ бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд шийдвэр гаргахыг шаарддаг. Корпораци нь 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон 6 сарын хугацааны бэлэн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөрт нийт \$892,014 ам.долларыг зарцуулсан (2017 онд \$1,407,437 ам.доллар).

Татвар

Корпорацийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын татвартай холбогдох хэсэгт удирдлагын зүгээс тайлан балансад хойшлуулсан татварын хөрөнгө, хойшлуулсан татварын тодорхой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлж, шийдвэр гаргана. Ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг төвлөрүүлэх эсэхээс хамаарч нөхөгдөх боломжтой тохиолдолд л татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлснээс, капиталын алдагдал болон түр зөрүүгээс үүсэх хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг төвлөрүүлэх тухай төсөөлөл нь ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын тооцооллоос хамаарна. Энэ бүхэн нь ирээдүйн үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ, нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээх зардал, капитал зардал, ногдол ашиг болон капиталын менежментийн бусад хэлцэл, гүйлгээнээс шалтгаална.

Түүнчлэн орлогын албан татварын хууль тогтоомжийн асуудлаар шийдвэр гаргах шаардлагатай. Нөхцөл байдлын өөрчлөлт нь тайлан балансад хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийн болон хойшлогдсон татварын өрийн дүн, хараахан хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа татварын бусад алдагдал болон түр зөрүүгийн дүнд нөлөөлж, хүлээгдэж буй үр дүнг өөрчлөх боломжтой тул эдгээр шийдвэр болон төсөөлөл нь эрсдэл болон тодорхой бус байдалд өртөх магадлалтай байдаг. Энэ тохиолдолд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн тохируулалт хийхэд орлогын тайланд харгалзах хөнгөлөлт, төлбөр үүснэ.

Корпорацийн нягтлан бодох бүртгэлийн гол тооцоололд сүүлийн 2 жилийн хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын хүрээнд 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж батлагдаад байна.

СТОУС 9 – Санхүүгийн хэрэглүүр

Олон улсын нягтлан бодох стандартын зөвлөл (ОУНББСЗ) нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 39-Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг орлох СТОУС 9-Санхүүгийн хэрэглүүр гэх стандартыг гаргасан. СТОУС 9 нь санхүүгийн тайланг ашиглан байгууллагын ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацаа, тодорхойгүй байдлыг үнэлж, дүгнэхэд нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр зэрэг шаардлагатай мэдээллийг тайлагнах зарчмыг тогтоох зорилготой.

НББОУС 12 – Орлогын албан татвар

Нэмэлт өөрчлөлтөөр хасагдах түр зөрүү нь зөвхөн тайлант хугацааны эцэст хөрөнгийн дансны үнийг хөрөнгийн татварын суурьтай харьцуулснаас бий болох ба үүнд дансны үнэд ирээдүйд гарах өөрчлөлт эсхүл хөрөнгийн нөхөгдөх байдал нөлөөлөхгүй болохыг тодорхой болгосон.

СТОУС 2 – Хувьцаанд суурилсан төлбөр

ОУНББСЗ нь хувьцаанд суурилсан төлбөрийн ангилал, хэмжилтийг тодорхой болгох зорилгоор СТОУС 2-Хувьцаанд суурилсан төлбөр стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн бүртгэл, хувьцаанд суурилсан төлбөрийн татварын үүрэгт төлөгдсөн цэвэр дүнгийн ангилал, өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөр бүхий ажил гүйлгээний өөрчлөлтийг бүртгэх зэрэг төлбөр тооцооны эцсийн хэлцэлд орох өөрчлөлтүүдийг хамарсан.

Олон Улсын Санхүүгийн Тайлагналыг Тайлбарлах Хороо (ОУСТТХ)-ын тайлбар 22: Гадаад валютын гүйлгээ ба урьдчилан тооцолт

ОУСТТХ нь 2016 оны 12-р сарын 8-нд ОУСТТХ-ын 22-р тайлбарыг гаргасан. Тус тайлбар нь гадаад валютын гүйлгээнд урьдчилгаа төлбөр эсхүл төлбөрийн баримт оролцсон тохиолдолд аль өдрөөр тооцох ёстойг тодруулсан.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарах ирээдүйн өөрчлөлтүүд

СТОУС-ын хүрээнд хийгдсэн дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбаруудыг 2018 оны 6-р сарын 30-наар тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглаагүй болно.

СТОУС 16 Түрээс: СТОУС 16 нь НББОУС 17-Түрээсийг орлоно

ОУСЗ 2016 оны 1 сарын 13-нд СТОУС 16-Түрээсийг гаргасан. Уг стандарт нь нягтлан бодох бүртгэлийн нэг түрээслэгчийн загварыг танилцуулсан ба үндсэн хөрөнгө нь бага өртөгтэй биш бол 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг түрээслэгчид тавьдаг. Түрээслэгч нь түрээслэсэн хөрөнгийг ашиглах эрхийг төлөөлсөн ашиглах эрхтэй хөрөнгийг ашиглах эрх, түрээсийн төлбөр төлөх үүргийг төлөөлсөн түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлага тавигддаг.

Корпораци нь 2019 оны 1-р сарын 1-нээс эхлэх санхүүгийн жилийн санхүүгийн тайлагналдаа СТОУС 16 стандартыг мөрдөхөөр зэхэж байна. Стандартыг мөрдсөнөөр бий болох нөлөөллийн цар хүрээг хараахан тодорхойлоогүй байгаа юм.

ОУСТТХ 23: Орлогын албан татварын бүртгэлийн тодорхойгүй байдал

ОУНББСЗ нь 2017 оны 6-р сарын 7-нд ОУСТТХ-ын 23-р тайлбарыг гаргасан. Уг тайлбар нь НББОУС 12 стандартын хүрээнд орлогын албан татварын бүртгэлтэй холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд татвар ногдох ашиг (татварын алдагдал), татварын суурь, ашиглагдаагүй татварын алдагдал, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт, татварын хувь хэмжээ зэргийг тодорхойлоход ашиглагдана.

Корпораци нь 2019 оны 1-р сарын 1-нээс эхлэх санхүүгийн жилийн санхүүгийн тайлагналдаа уг тайлбарыг мөрдөхөөр зэхэж байна. Тус тайлбар нь санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж Корпораци үзсэн болно.

Санхүүгийн хэрэгсэл ба бусад эрсдэл

Санхүүгийн хэрэгсэл

Корпорацийн санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэн нь дансны үнэтэйгээ ойролцоо гэж үзэв. Бодит үнэ цэн гэдэг нь зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө борлуулсны дүнд хүлээн авах эсхүл дэс дараатай хэлцэл гүйлгээгээр өр төлбөрийг шилжүүлэхээр төлсөн хэлцэл гүйлгээний өдрөөр үнэлэгдэх үнэ юм. Бодит үнэ цэнийн эрэмбэ нь бодит үнэ цэнийг хэмжих үнэлгээний арга техникт орцыг ангилах түвшнүүдийг тогтоодог.

Түвшин1: Идэвхтэй зах зээлд нэг төрлийн хөрөнгө эсхүл өр төлбөрийн орц нь тогтоосон үнэ байна.

Түвшин 2: Орц нь идэвхтэй бус зах зээлийн тогтоосон үнэ, идэвхтэй зах зээл дэх ижил төстэй хөрөнгө буюу өр төлбөрийн тогтоосон үнэ, хөрөнгө эсхүл өр төлбөрийн хувьд хэмжиж болохуйц тогтоосон үнээс бусад орц, эсхүл хэмжиж болохуйц зах зээлийн дүн мэдээгээр болон бусад хэрэгслээр нотлогдсон буюу эдгээрээс голчлон бий болсон орц байна.

Түвшин 3: Орц нь хэмжиж болохуйц бус (зах зээлийн үйл ажиллагаагаар огт дэмжигдээгүй буюу өчүүхэн дэмжигдсэн) байна.

Бодит үнэ цэнэ

2017 оны 12-р сарын 31-нээс 2018 оны 6-р сарын 30-ныг хүртэлх хугацаанд Түвшин 1, Түвшин 2, Түвшин 3-ын хооронд ангилагдсан хөрөнгө, өр төлбөрийн хэлцэл гүйлгээ байхгүй байна. Дараах хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ болон эрэмбэд эзлэх түвшнийг харуулав.

	2018.06.30			2017.12.31		
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Санхүүгийн хөрөнгө:						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	\$ 5,146,759	\$ -	\$ -	\$ 3,225,202	\$ -	\$ -
Авлага	-	155,343	-	-	148,069	-

Эрсдэлүүд

Корпораци нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа голчлон хайгуулын үр дүн, металл болон түүхий эдийн үнэтэй холбоотой үндсэн өрийн эрсдэл, тодорхой бус байдалтай тулгарсан. Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт нь олон эрсдэл дагуулдгийн ихэнх нь Корпорацийн хяналтаас давсан байдаг. Корпораци нь дэд бүтэц, хүртээмж сул хөгжсөн алслагдмал байршилд үйл ажиллагаа явуулдаг гадна хайгуул, ашиглалтын хэвийн болон ердийн эрсдэлүүдтэй тулгарч байдаг.

Зээлийн эрсдэл

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн өндөр эрсдэлийг дагуулдаг. Тайлант өдрөөр хамгийн дээд алдагдлыг дор үзүүлэв. Үүнд:

	Дансны үнэ	
	2018.06.30	2017.12.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	\$ 5,146,759	\$ 3,225,202
Авлага	155,343	148,069
	\$ 5,302,102	\$ 3,373,271

Авлага гэдэгт Морейнээс авах дүн багтана. Корпораци нь Морейн компанид менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээтэй ба төлбөрийг сар бүр нэхэмжилдэг. 2018 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар Морейноос авах авлага нийт авлагын 14%-ийг эзэлж байна (2017 оны 12-р сарын 31-ний байдлаар 18% байсан). Удирдлагын багийн зүгээс авлагын дүнд үзүүлэх зээлийн эрсдэл бага гэж үзэв.

Хөрвөх (төлбөр түргэн гүйцэтгэх) чадварын эрсдэл

Төлбөр түргэн гүйцэтгэх (хөрвөх) чадварын эрсдэл нь бэлэн мөнгө болон санхүүгийн бусад хөрөнгийг гарган өгөх замаар шийдвэрлэх санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд нь Корпорацид тулгарч болох бэрхшээл юм. Корпораци нь хэвийн болон дарамттай аль ч нөхцөлд өр төлбөрөө цагт нь төлөх хангалттай хэмжээний төлбөрийн чадвартай байх үүднээс төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа удирдана. Корпорацийн бэлэн мөнгөний үлдэгдэл 2018 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар \$507,973 долларын (December 31, 2017 - \$191,600) богино хугацаат өр төлбөрийг төлж барагдуулахуйц буюу \$5,146,759 доллар (2017 оны 12-р сарын 31-ний байдлаар \$3,225,202 доллар байсан) байна.

Корпораци нь хайгуулын шатандаа яваа бөгөөд үүнд хайгуулын шатанд яваа харьцуулж болох бусад компаниудын нэгэн адилаар эрсдэл, сорил бэрхшээл тулгарч болно. Эдгээр эрсдэлүүдэд гол ажилтнуудаас хамааралтай байх, хайгуулын үр дүн амжилттай байх, төслүүдийг амжилттай урагшлуулж, тасралтгүй ажиллах зарчмыг хангахад шаардагдах хамгийн бага капитал нөөцийг баталгаажуулах чадвар зэргийг багтаах боловч зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана.

Корпорацийн одоогийн эргэлтийн хөрөнгө болох \$3.95 сая ам.доллар нь 2019 оны нэгдүгээр улирал хүртэл төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд хангалттай бөгөөд шаардлагатай гэж үзвэл төлөвлөгдсөн зардлыг хойшлуулах замаар энэ хугацааг сунгах боломжтой. Корпораци тасралтгүй ажиллагааны зарчмыг хангаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа үед хөрөнгөө борлуулж, өр төлбөрөөс чөлөөлөгдөх буюу хайгуулын хөтөлбөрүүдээ өргөжүүлэх чадвар нь хөрөнгийн санхүүжилтээ баталгаажуулах, хамтын хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулах буюу санхүүжилт босгох зэргээс шалтгаална. Нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэх, хугацаа төлөвлөлт зэрэг нь Корпорацийн хайгуулын тасралтгүй үргэлжлэх хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаар тодорхойлогдоно.

Гадаад валютын эрсдэл

Корпораци нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг тул гадаад валютын хөрвүүлгийн ханшийн эрсдэл өндөр байна. Уг эрсдэлээс сэргийлэх зорилгоор Корпораци нь мөнгөө Канадын өндөр зэрэглэлийн санхүүгийн байгууллагад байршуулдаг. Корпораци нь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эсрэг ямар нэгэн хэджингийн хэрэгсэл ашигладаггүй бөгөөд хайгуулын хөтөлбөрийн хуваарьт тулгуурлан Компанийн төсвийн хэмжээнд нийцүүлэн ханш боломжийн байх үед гадаад валютыг урьдчилан худалдаж авдаг.

Корпорацийн ам.долларын ханшийн эрсдэлд өртөх байдал 2018 оны 6-р сарын 30-ны байдлаар \$1,070,151 доллар байна (2017 оны 12-р сарын 31-ний байдлаар \$205,773 доллар байв). Корпорацийн америк долларын ханшийн нэмэх, хасах 10%-ийн өөрчлөлтөд мэдрэг байдал нь цэвэр алдагдал, дэлгэрэнгүй алдагдал, хохиролд ойролцоогоор \$107,000 долларын (2017.12.31 - \$20,600) нөлөө үзүүлнэ.

Корпорацийн төгрөгийн ханшийн эрсдэлд өртөх байдал 2018 оны 6-р сарын 30-ны байдлаар \$283,797 доллар байна (2017 оны 12-р сарын 31-ний байдлаар \$38,526 доллар байсан). Төгрөгийн ханшийн нэмэх, хасах 10%-ийн өөрчлөлтөд мэдрэг байдал нь цэвэр алдагдал, дэлгэрэнгүй алдагдал, хохиролд ойролцоогоор \$28,400 долларын (2017.12.31 - \$3,900) нөлөө үзүүлнэ.

Үнийн эрсдэл

Корпораци нь тодорхой ашиг олоогүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэглүүрүүд, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт

Эрдэнэ Ресурс нь Канад улсын Үнэт цаасны зохицуулалтын 52-109 стандартаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал (ГЗ), Санхүү хариуцсан захирал (СХЗ) нар Эрдэнэ Ресурсын 2018 оны 6-р сарын 30-ны байдлаарх толилуулгын хяналт, процедурын зохион байгуулалт, үр нөлөөг үнэлж үзээд эдгээр процедур нь Эрдэнэ Ресурс, түүний охин компаниудтай холбоотой материаллаг мэдээллийг бусаддаа үнэн зөв, бүрэн бүтэн толилуулах, жилийн тайлагналыг үндэслэлтэй гаргах боломжийг бүрдүүлсэн, үр нөлөө бүхий байна хэмээн дүгнэсэн.

ГЗ, СХЗ-ыг багтаасан Эрдэнийн удирдах баг (хамтад нь “Удирдах баг” гэх) нь санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Санхүүгийн тайлагналд тавих Эрдэнэ Ресурсын дотоод хяналт (аудит) нь санхүүгийн тайлагналын найдвартай байдлыг хангаж, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд анхаарна.

Удирдлага нь 2018 оны 6-р сарын 30-ны байдлаарх Эрдэнэ Ресурсын санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ийнхүү үнэлэхдээ Удирдлага нь Ивээн тэтгэгч байгууллагуудын хороо (Committee of Sponsoring Organizations of the Treadway Commission)-ны “Дотоод хяналт-нэгдсэн зохицуулалтын орчин (2013)” гэх тайланд тогтоосон шалгууруудыг ашигласан. Үнэлгээгээр гол эрсдэлтэй салбаруудын хяналтыг шалгаж, эдгээр хяналтуудын хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөг нь тодорхойлох зорилгоор тэдгээр хяналтуудыг туршиж, үр дүнг нь хянаж, улмаар нэгдсэн дүгнэлт гаргасан.

Удирдлагын үнэлгээнд үндэслэн ГЗ болон СХЗ нар 2018 оны 6-р сарын 30-наарх Эрдэнэ Ресурсын санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт нь санхүүгийн тайлагналын үнэн зөв, найдвартай байдлыг хангах, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд үр налаатэй байна гэж дүгнэсэн.

Мэргэшсэн этгээд

Майкл А.МакДоналд, мэргэшсэн геосудлаач, (Нова Скотиа) нь NI 43-101 стандартын дагуу шаардлага хангасан этгээд болж буй бөгөөд Корпорацийн хайгуулын бүх хөтөлбөрийг удирдан чиглүүлнэ. Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хотноо, эсвэл Хятадын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори (SGS Laboratories), Улаанбаатар дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Коуст Рисерч Лтд (Blue Coast Research Ltd) эсвэл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь бэлтгэсэн стандарт, хээрийн болон лабораторийн хуваалт, бэлдэцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (QA/QC)-ын протоколыг гүйцэтгэнэ.

Энэхүү УХДШ-д толилуулсан Корпорацийн эзэмшиж буй ашигт малтмалын төслүүдийн шинжлэх ухааны болон техникийн мэдээллийг Корпорацийн хараат мэргэшсэн геосудлаач Майкл А.МакДоналд хянан батласан болно.

Бусад мэдээлэл

Корпорацийн жилийн мэдээ тайлан гэх мэт Корпорацийн талаарх нэмэлт мэдээллийг www.sedar.com хаягт байх SEDAR болон www.erdene.com хаяг дахь Корпорацийн цахим хуудаснаас үзэх боломжтой.